



СОЁМБО



БАТЛАН ХАМГААЛАХ, ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ ТӨВ ХЭВЛЭЛ

2020.08.13 №31 (10708)

Үнэ 500 төгрөг

Дугаар эрхэлсэн ахлах дэслэгч М.МӨНХЗОРИГ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ ТӨМӨР ЗАМЫН БҮТЭЭН БАЙГУУЛАЛТТАЙ ТАНИЛЦЛАА



Монгол Улсын Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний Ерөнхий командлагч Х.Баттулга, Зүүнбаян-Тавантолгой чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтын ажилтай танилцлаа. Монгол Улсын Ерөнхийлөгчийг

дагалдаж УИХ-ын гишүүн Б.Дэлгэрсайхан, Засгийн газрын гишүүн, Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр, Зэвсэгт хүчний Жанжин штабын дарга, хошууч генерал Д.Ганзориг, Батлан хамгаалах яамны Бодлогын

хэрэгжилтийг зохицуулах газрын дарга, хурандаа Х.Батсайхан болон албаны бусад хүмүүс ажиллалаа. Зүүнбаян-Тавантолгой чиглэлийн төмөр замын доод бүтцийн буюу далангийн ажлыг Зэвсэгт хүчний бие

бүрэлдэхүүн, дотоодын аж ахуйн нэгжүүдтэй хамтран амжилттай хийж гүйцэтгэснээс гадна өртөө болон зөрлөгийн ажлыг хариуцаж эхнээс нь ашиглалтад оруулаад байгаа юм. Зөрлөгийн болон ажилчдын орон сууцыг байгуулахдаа халуун, хүйтэн ус, халаалттай байхаар шийдсэн байна. Энэ нь дараа, дараагийн өртөө зөрлөгт жишиг болсон аж.


Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр, Зэвсэгт хүчний Жанжин штабын дарга, хошууч генерал Д.Ганзориг нарыг төмөр замын бүтээн байгуулалтын ажилтай танилцах үеэр Зэвсэгт хүчний 7781 дүгээр ангийн захирагч, хошууч генерал П.Доржсүрэн болон "Улаанбаатар төмөр зам" ХНН-ийн дарга Д.Жигжиднямаа нар ажлын явц, гүйцэтгэлийн талаар танилцуулж, дэлгэрэнгүй мэдээлэл өгөв. Мөн Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаярт төмөр замын бүтээн байгуулалтад оролцож буй дотоодын аж ахуйн нэгжүүдийн алба хаагчид Зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүнтэй хамтран түүхэнд үлдэх бүтээн байгуулалтад гар нийлэн ажиллаж байгаадаа сэтгэл хангалуун байгаагаа илэрхийлсэн юм. Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр өнгөрсөн долоо хоногт Зэвсэгт хүчний Жанжин штаб, Зэвсэгт хүчний 336 дугаар ангид ажилласан бол амралтын өдрүүдэд ийнхүү төмөр замын бүтээн байгуулалттай танилцлаа.

БНТУ-ААС МОНГОЛ УЛСАД СУУГАА ЭЛЧИН САЙД АХМЕТ ЯЗАЛЫГ ХҮЛЭЭН АВЧ УУЛЗАВ

Засгийн газрын гишүүн, Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр Бүгд Найрамдах Турк Улсаас Монгол Улсад суугаа Элчин сайд Ахмет Язалыг хүлээн авч уулзав. Уулзалтын эхэнд Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр Монгол Улсын Гадаад бодлогын үзэл баримтлалд БНТУ-ыг гуравдагч хөрш хэмээн заасан бөгөөд хоёр улс нь түүх, соёлын уламжлалаа эрхэмлэн, найрсаг харилцаа, хамтын ажиллагаагаа өргөжүүлэн хөгжүүлж байгаад баяртай байдгаа илэрхийлэв. Мөн цэргийн санхүүгийн хамтын ажиллагааны хүрээнд манай Зэвсэгт хүчний шинэчлэлийг дэмжин буцалтгүй тусламж, дэмжлэг үзүүлсээр ирсэнд БНТУ-ын Засгийн газар, Үндэсний Батлан хамгаалах яаманд талархал илэрхийллээ. Түүнчлэн, талууд 1999 онд Батлан хамгаалах салбарт албан ёсны харилцаа тогтоосноос хойш цэргийн сургалт бэлтгэл, энхийг дэмжих ажиллагааны чадварыг

дээшлүүлэх зэрэг олон чиглэлээр хамтран ажиллаж байгааг тэмдэглэн хэлэв. Элчин сайд Ахмет Язал

гэдэгт итгэлтэй байгаагаа илэрхийлэв. Элчин сайд Ахмет Язал Турк улсын цэрэг,



Г.Сайханбаярыг Монгол Улсын Батлан хамгаалахын сайдаар томилогдсон баяр хүргээд, Батлан хамгаалах салбарын бодлого, гадаад харилцаа, хамтын ажиллагааны өргөн мэдлэг, арвин туршлагатай мэргэжлийн сайд томилогдсон баяртай байгаа бөгөөд цаашид хоёр орны батлан хамгаалах харилцаа, хамтын ажиллагааг баяжуулан хөгжүүлэхэд ихээхэн хувь нэмэр оруулна


армийн түүх нь Монгол Улсаас эхлэлтэй болохыг онцлоод өнөөгийн Зэвсэгт хүчинд хэрэглэгдэж байгаа цолны нэршлүүд нь аравт, зуут, мянгатын дарга гэх мэт эртний Монгол цэргийн аравтын системээс үүсэлтэй тухай нэмж хэлсэн юм. Уулзалтын төгсгөлд, талууд Монгол Туркийн батлан хамгаалах харилцаа, хамтын ажиллагаа цаашид улам амжилттай хөгжинэ гэдэгт итгэлтэй байгаагаа илэрхийлэв.

ДЭЙВ ВОУСЕН: ХОЁР ТАЛЫН САЛБАРЫН ХАРИЛЦАА ЭРЧИМТЭЙ ХӨГЖИЖ БАЙНА

Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр Австрали Улсаас Монгол Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Дэйв Воусэнийг хүлээн авч уулзлаа. Элчин сайд Воусэн Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаярт өндөр хариуцлагатай бөгөөд нэр хүндтэй албанд томилогдсон нь баяр хүргээд Монгол, Австралийн Батлан хамгаалах бодлого, хамтын ажиллагааны яриа хэлэлцээр, зөвлөлдөх уулзалтуудыг удаа дараа ахлан, хоёр талын харилцааг бэхжүүлэх үйлсэд анхаарлаа хандуулан, үнэтэй хувь нэмэр оруулж ирсэнд талархаж байгаагаа илэрхийлэв. Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр "Батлан хамгаалах яамд хоорондын санамж бичиг"-ийг 2015 онд байгуулсан нь Батлан хамгаалах салбарын харилцааг богино хугацаанд эрчимтэй хөгжихөд ихээхэн түлхэц болсон гэдгийг

онцоллоо. Мөн тэрээр батлан хамгаалах хамтын ажиллагааны хүрээнд харилцан тохиролцсон арга хэмжээүүдийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлж байдаг эрхэм Элчин

хязгаарлагдахгүй дэлхий нийтийг хамарсан цар тахал, байгалийн гамшиг, бүтээн байгуулалт зэрэг бүхий л салбарт голлох болсон гэдэгт санал нэгддэг гэв. Уулзалтын төгсгөлд




сайд, Австралийн Элчин сайдын яам, Монгол Улсад хавсран суугаа Батлан хамгаалахын атташе нарт хариу талархал илэрхийлэв. Түүнчлэн талууд Зэвсэгт хүчин, бие бүрэлдэхүүний гүйцэтгэх үүрэг зөвхөн батлан хамгаалах салбараар

Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр болон эрхэм Элчин сайд Дэйв Воусэн нар Монгол, Австралийн Батлан хамгаалах харилцаа, хамтын ажиллагаа цаашид улам амжилттай хөгжинэ гэдэгт итгэлтэй байгаагаа харилцан илэрхийлсэн юм.

НОЁН ГРИГОРИ МЭЙГ ХҮЛЭЭН АВЧ УУЛЗЛАА

Батлан хамгаалахын дэд сайд Б.Баярмагнай Америкийн Нэгдсэн Улсаас Монгол Улсад суугаа Элчин сайдын яамны Дэд тэргүүн Григори Мэйг хүлээн авч уулзлаа.

Уулзалтын үеэр дэд сайд Б.Баярмагнай Монгол, Америкийн Нэгдсэн Улс хоорондын Батлан хамгаалах салбарын харилцаа, хамтын ажиллагааны хөгжилд сэтгэл хангалуун байдгаа онцолж, энэхүү харилцааг хөгжүүлэхэд үнэтэй хувь нэмэр оруулдаг нь АНУ-ын Элчин сайдын яам, Дэд тэргүүн болон Батлан хамгаалахын атташегийн албанд талархал илэрхийлэв. Тэрбээр хоёр орны уламжлалт найрсаг харилцааг улам батжуулж, хамтын ажиллагааг баяжуулан хөгжүүлэхэд хүчин чармайлт гарган ажиллана гэдгээ мэдэгдлээ.



Ноён Григори Мэй Б.Баярмагнайд Батлан хамгаалахын дэд сайдаар томилогдсон явдалд баяр хүргэж амжилт хүсэхийн ялдамд одоо хэрэгжүүлж

байгаа хамтын ажиллагааны төсөл, хөтөлбөр, үйл ажиллагаанууд амжилттай хэрэгжинэ гэдэгт итгэлтэй байгаагаа илэрхийлснээр уулзалт өндөрлөлөө.

ЗӨӨВРИЙН АМЬСГАЛЫН АППАРАТ ГАРДУУЛАН ӨГЛӨӨ

Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр Холбооны Бүгд Найрамдах Герман Улсаас Монгол Улсад суугаа Элчин сайд Ёорн Розенбергийг хүлээн авч уулзав. Уулзалтаар хоёр улсын батлан хамгаалах салбарын харилцаа, хамтын ажиллагааны асуудлаар санал солилцов. Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр Монгол Улс ХБНГУ-тай иж бүрэн түншлэлийн харилцаа амжилттай хөгжиж байгаа, тэр дундаа батлан хамгаалах салбарын харилцаа идэвхжиж, өндөр түвшний харилцан айлчлал, зөвлөлдөх уулзалт тогтмолжиж, энхийг дэмжих ажиллагаанд хамтран оролцох, цэргийн сургалт бэлтгэл, уулын явган цэргийн хамтын ажиллагаа, цэргийн эмнэлэг зэрэг чиглэлээр өргөжин хөгжиж байгаад сэтгэл хангалуун байгаагаа онцлон тэмдэглэв.

Мөн дэлхий дахинд нүүрлэсэн шинэ төрлийн коронавирусийн цар тахлын үед ХБНГУ-ын Засгийн газар, Холбооны Батлан хамгаалах яамны зүгээс Батлан хамгаалах яамны харьяа Цэргийн төв эмнэлэгт 1 сая еврогийн эмнэлгийн тоног төхөөрөмжийн буцалтгүй тусламжийг үзүүлсэн нь цар тахлаас урьдчилан



сэргийлэх, түүнийг даван туулах ажилд ихээхэн хувь нэмэр болсныг онцлон Монгол Улсын Засгийн газар, БХЯ-ны нэрийн өмнөөс талархлаа илэрхийлэв. Элчин сайд Ёорн Розенберг Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаярт сайдаар томилогдсон сайд томилогдсон нь хоёр талын цаашдын харилцаа, хамтын ажиллагааг амжилттай хөгжүүлэхэд чухал ач холбогдолтойг онцлов.

Уулзалтын төгсгөлд, Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Холбооны Батлан хамгаалах яамнаас Монгол Улсын Батлан хамгаалах яаманд коронавирусийн цар тахалтай тэмцэх мөн Зэвсэгт хүчний эрүүл мэндийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэхээр буцалтгүй тусламжаар олгож буй 20 ширхэг зөөврийн амьсгалын аппаратыг Элчин сайд Ёорн Розенберг Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаярт гардуулж өглөө.

“ФРОНТ” ХЭМЭЭН АЛДАРШСАН С.ЦЭГМИДЭД ГАВЬЯАТ МАЛЧИН ЦОЛ ХҮРТЭЭВ

Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулга Дундговь аймагт ажиллаж, шинэ зам болон бусад бүтээн байгуулалтын ажлын явцтай танилцав. Энэ үеэр Дундговь аймгийн Сайхан-Овоо сумын харьяат, “Фронт” хэмээн алдаршсан С.Цэгмидэд Монгол Улсын гавьяат малчин цол хүртээлээ.

Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулга баяр хүргэж үг хэлэхдээ, “Өнөөдөр одонгоо гардаж байгаа олон эхчүүдийн хамт нэгэн буянтай бууралд Монгол Улсын гавьяат малчин цол, тэмдгийг гардууллаа. Энэ хүн бол Дундговь аймгийн Сайхан-Овоо сумын харьяат “Фронт” хэмээн алдаршсан Сүрэнхорын Цэгмид гуай юм. Тэрбээр 1942 оны 12 дугаар сард 19-хөн настайдаа Зөвлөлтийн Улаан армид бэлэг хүргэх төлөөлөгчдийн бүрэлдэхүүнд орж, Свердловск орчмын фронтын тэргүүн шугам дээр очиж байсан юм. Монгол Улсаас илгээсэн бэлгийн гурав дахь цуваагаар 217 вагон бүхий дээл хувцас, арьс нэхий, мах, хүнсний зүйлс хүргэж, мөн ард түмний хөрөнгөөр боссон 40



танкийг чин сэтгэлийн дэмжлэг болгон хүлээлгэн өгч байжээ.

С.Цэгмид гуайг сар гаруйн өмнөхөн Оросын Холбооны Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар Аугаа Эх орны дайны ялалтын 75 жилийн ойн медалиар шагнасан. Үйлс буян нь дэлгэрсэн бууралдаа зуу насалж, зургаадай таяг тулахын ерөөлийг дэвшүүлэе” гэлээ.

БАТЛАН ХАМГААЛАХЫН САЙД ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ 336 ДУГААР АНГИД АЖИЛЛАЛАА



Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр Жанжин Д.Сүхбаатарын нэрэмжит Зэвсэгт хүчний 336 дугаар ангид ажиллалаа.

Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаярыг дагалдан Батлан хамгаалах яамны Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга, хурандаа Х.Батсайхан, Зэвсэгт хүчний Жанжин штабын дарга, хошууч генерал Д.Ганзориг, Зэвсэгт хүчний Хуурай замын цэргийн штабын дарга, бригадын генерал Л.Онцгойбаяр нарын албаныхан ажиллав. Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаярыг хүндэт харуул жагсаж угтсаны дараа ангийн захирагч, хурандаа А.Болдбаатар хорооны түүхэн замнал, ололт амжилт, үүрэг гүйцэтгэлт, бэлэн байдлыг дээшлүүлэхэд авч хэрэгжүүлсэн ажил, арга хэмжээ, тулгамдаж буй асуудлын талаар танилцуулав. Түүнчлэн цэргийн гэрээт болон хугацаат цэргийн алба хаагчдын байр, цэргийн гал тогоо, эрүүл мэндийн төв, угаалгын газар болон цаашид засварлаж, сайжруулах шаардлагатай зарим

барилга байгууламжтай биечлэн танилцлаа.

Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр үргэлжлүүлэн ангийн бие бүрэлдэхүүнтэй уулзаж, Засгийн газар, Батлан хамгаалах салбарын цаашдын бодлого, Зэвсэгт хүчний өөрчлөлт, шинэчлэлийн талаар танилцуулсан юм. Тухайлбал, “Сая ангийн танилцуулгыг сонсоод сууж байхад та бүхэн анги, хамт олноороо олон ажил зохион байгуулсан байна. Хүнтэйгээ тулж ажилладаг, хүнээ боддог чадварлаг ажилтнууд тус ангийн удирдлагаар томилогдон ажиллаж байгаад баяртай байна. Миний хувьд энэ салбарт тасралтгүй 35 жил зүтгэсэн хүний хувьд салбарынхаа үүрэг гүйцэтгэх боломж, дэвшүүлсэн зорилго, зорилтууд, бие бүрэлдэхүүний мэргэжлийн ур чадвар, дадлага, туршлага, тулгамдаж буй асуудлын талаар маш сайн мэднэ.

Ялангуяа, цэргийн жинхэнэ алба хаах тогтолцоог илүү төгөлдөржүүлэх, мэргэжлийн цэрэгт суурилсан Зэвсэгт хүчнийг хөгжүүлэх, зэвсэг, техникийн бэлэн байдлыг

хангах чиглэлд түлхүү анхаарч ажиллана. Манай цэргийн алба хаагчид өөрийн ажил, үүргээ бахархал талаас нь харж байгаасай. Өнөөдөр цэргийн алба хаагчид улс орны бүтээн байгуулалтыг нуруундаа үүрч, дэлхийн халуун цэгүүдэд энхийг сахиулах үүргээ нэр төртэй гүйцэтгэж байгааг бид бүхэн харж байна. Төмөр замын бүтээн байгуулалтын далангийн ажлыг 100 хувь хийж дуусгасан. Одоо төмөр замын трассыг тавьж суурилуулах ажилд үүрэг гүйцэтгэж байгаа. Сүүлийн жилүүдэд улс орны стратегийн хэмжээний томоохон бүтээн байгуулалтад Зэвсэгт хүчний алба хаагчид гар бие оролцсон” хэмээн онцолсон юм. Мөн үргэлжлүүлэн хөдөө орон нутаг дахь Зэвсэгт хүчний нэгтгэл, ангиудын туслах аж ахуйг хөгжүүлж, өөрсдийн нормын хүнсний хэрэгцээг тариалаад, бие бүрэлдэхүүнээ эрүүл хүнсээр хангах ажлыг нь дэмжинэ. Энэ нь мэдээж зохистой харьцаанд байх хэрэгтэй. Тариалсан хүнсний ногооныхоо үр шимийг нь бүрэн дүүрэн хүртдэг байх ёстой хэмээн онцлов.

БАТЛАН ХАМГААЛАХЫН ДЭД САЙД ХАРЬЯА БАЙГУУЛЛАГУУДАД АЖИЛЛАЛАА

Батлан хамгаалахын дэд сайд Б.Баярмагнай, БХЯ-ны Төрийн захиргааны удирдлагын газрын дарга, хурандаа Д.Баасандамба нар ЦДБЭЧ-ын үйл ажиллагаатай танилцав. Энэ үеэр ЦДБЭЧ-ын дарга, Соёлын төв өргөөний ерөнхий менежер, хурандаа

ой тохиож байгаатай холбогдуулан чуулгаас хэрэгжүүлэхээр төлөвлөсөн төсөл, хөтөлбөрүүдийн талаар санал дэвшүүлэв. Нэгдсэн танилцуулгын дараа тус чуулгын удирдлага, байгууллагын үүрэг гүйцэтгэлийн өнөөгийн байдал, өдөр тутмын үйл ажиллагаа, сургалт, дасгалын танхимууд, албаны өрөө, тасалгааны ашиглалт, тоглолтын хувцас хэрэгсэл, техник, тоног төхөөрөмжийн хангалт, ашиглалт, алба хаагчдын ажиллах орчин, нөхцөлийн талаар биечлэн танилцуулж, урлагийн хэсэгчилсэн тоглолтоор үйлчиллээ.

Дараа нь Батлан хамгаалах, Зэвсэгт хүчний төв хэвлэл “Соёмбо” сонины үйл ажиллагаатай танилцлаа. Тус сонины эрхлэгч, хурандаа Б.Отгонбаяр “Соёмбо” сонины түүх, үйл ажиллагааг танилцуулсны дараа Батлан хамгаалахын дэд сайд Б.Баярмагнай сонины хамт олонд хандан хэлсэн үгэндээ “Өнө удаан жилийн түүхийн хуудастай, дайны утаа үнэрлэсэн сонинхоо улбааг үргэлжлүүлэн өнөө цагт амжилттай авч яваа нь та бүхний итгэл, сэтгэлийн үр дүн юм. Цаашид сонинхоо үйл ажиллагааг улам төгөлдөржүүлж, мэдээллийн технологи, цахим орчны эрин үетэй хөл нийлүүлэн алхахад анхаараарай” гэв.



Г.Золзаяа чуулгын түүхэн замнал, 2020 оны “Гүйцэтгэлийн төлөвлөгөө”-ний эхний хагас жилийн хэрэгжилтийн талаар танилцуулж, 2021 онд Монгол Улсад Батлан хамгаалах алба байгуулагдсаны 110, шинэ цагийн Зэвсэгт хүчний 100 жилийн

БАТЛАН ХАМГААЛАХЫН САЙД ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ ЖАНЖИН ШТАБТ АЖИЛЛАХ ҮЕЭР ...

Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр 2020 оны 8 дугаар сарын 4-ний өдөр Зэвсэгт хүчний Жанжин штабын үйл ажиллагаатай танилцах үеэрээ Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөртэй уялдуулан Батлан хамгаалах яамнаас баримтлах бодлого, зорилт, хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэлийг танилцуулав.

Сайд Г.Сайханбаяр ЗХЖШ-ын удирдах бүрэлдэхүүнд хандаж хэлсэн үгэндээ “Монгол Улсын Их Хурлын ээлжит сонгуулийн үр дүн, Монгол Улсын Үндсэн хуулийн өөрчлөлтийн хүрээнд шинэ Засгийн газар эмхлэн байгуулагдаж, энэхүү Засгийн газарт миний бие Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Батлан хамгаалахын сайдаар томилогдон анхны уулзалтаа Зэвсэгт хүчний Жанжин штабын удирдлага, нийт бие бүрэлдэхүүнтэй хийж байгаадаа баяртай байна. Батлан хамгаалах салбарт ажил, амьдралаа зориулсан надад энэхүү нэр хүндтэй бөгөөд хариуцлагатай үүргийг даалгасан нь Батлан хамгаалах, Зэвсэгт хүчний өмнө дэвшигдэн тавигдаж буй зорилт, үйл ажиллагааг хэрэгжүүлэх өндөр итгэл, найдвар хүлээлгэсэн гэж ойлгож байгаа” хэмээн дурдаад дараах үүрэг, чиглэлийг өгсөн юм. Үүнд:

1.“Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, түүнд Батлан хамгаалахын талаар туссан зорилттой нийцүүлэн “Зэвсэгт хүчний байгуулалтыг 2024 он хүртэл хөгжүүлэх хөтөлбөр”-ийн төслийг эргэлтийн чанартай томоохон зарчмуудыг тусгаж, хэрэгжүүлэх арга хэмжээг биелэгдэх боломжтой, үнэн бодитой, үр дүнг чанарын өөрчлөлт гарахаар, хэмжигдэхүйц байхаар тооцон боловсруулж, батлуулах, хэрэгжилтийг нь зохион байгуулах;

2.2018 онд Монгол Улсын Ерөнхийлөгч зарлиг гаргаж “Төрийн цэргийн номлол” баримт бичгийг шинээр баталснаар стратегийн төлөвлөлтийн баримт бичгүүдийг боловсруулах нөхцөл бүрдсэн тул тус номлолын үзэл санаанд нийцүүлэн Зэвсэгт хүчний стратегийн төлөвлөлтийн баримт бичгүүдийг боловсруулж дуусгах;

3.Зэвсэгт хүчний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт орж Зэвсэгт хүчин нь барилга-инженер, кибер аюулгүй байдал болон тусгай хүчний төрлийн цэрэгтэй болсон. Зэвсэгт хүчний бүтцэд барилга-инженерийн, кибер аюулгүй байдлын болон тусгай хүчний удирдлагын нэгжүүдийг байгуулах, бэхжүүлэх арга хэмжээний төлөвлөлт, гүйцэтгэлийг эрчимжүүлэх;

4.Зэвсэгт хүчний зэвсэглэл, цэргийн техникийг шинэчлэх, сэргээн сайжруулах талаар ажил, арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж байгаа. Удаан хугацааны хадгалалтад байгаа зэвсэг, техникийг сэргээн сайжруулах үйл ажиллагааг үе шаттайгаар, өөрсдийн нөөц бололцоонд тулгуурлан, сэтгэл гаргаж нэгтгэл, ангийн түвшинд хэрэгжүүлэх;

5.Зэвсэгт хүчний бүтэц, зохион байгуулалтыг төгөлдөржүүлэх, хүний нөөцийн чадавхыг дээшлүүлэх шаардлага байна. Тиймээс Батлан хамгаалахын хүний нөөцийн бодлого, хүний нөөцийн дунд хугацааны төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж, Төрийн албаны тухай хуультай нийцүүлэн офицеруудыг боловсрол, мэргэжил, туршлага, ур чадвар, төлөвлөөр нь сонгон шалгаруулах, шатлан дэвшүүлэх зарчмыг мөрдлөг болгох;

6.Зэвсэгт хүчний олон жилийн уламжлалт хэв загварыг баримталсан сургалтын тогтолцооны загвараас татгалзаж цэргийн сургалт, бэлтгэлийн удирдлага, төлөвлөлт, зохион байгуулалтыг шинэчлэх, сургалтад шаардлагатай бүх талын нөөцийг нэмэгдүүлэх;

7.Офицер, ахлагч бэлтгэх цэргийн мэргэжлийн сургалтын чанарыг дээшлүүлэхийн тулд Зэвсэгт хүчний нэгтгэл, анги, УБХИС-ийн хамтын ажиллагааг сайжруулж, анги, салбар дахь мэргэжлийн дадлага, сургалтыг нэмэгдүүлэх, хамтарсан хэргийн сургуулийг УБХИС-ийн ЦНДС, Зэвсэгт хүчний нэгтгэл, ангийг оролцуулан зохион байгуулах;

8.Офицер, ахлагч нарыг шаталсан сургалтаар болон ажлын байран дээр нь тасралтгүй хөгжүүлж, боловсролын болон албан тушаалын сургалтын сонгон шалгаруулалтын шаардлага, шалгуур үзүүлэлтийг бүрэн хангасан нөхцөлд суралцуулах;

9.Зэвсэгт хүчний нэгтгэл, анги, байгууллагыг хүний хөгжлийн орчин болгох, алба хаагчдад ажиллах, амьдрах ая тухтай орчныг бүрдүүлэхэд онцгойлон анхаарал хандуулж Зэвсэгт хүчний нэгтгэл, анги, салбаруудын үйл ажиллагаа, өнөөгийн бодит байдалтай биечлэн танилцаж, асуудлын гүнд нь орж ажиллана. Хуучны баригдмал хэв загвараас аль болох татгалзаж, хүнийг хөгжүүлэх талаас нь харан, хөгжлийн орчныг шинэлэг хэлбэрээр бүрдүүлж, цэргийн гэрээт болон хугацаат цэргийн алба хаагчдын алба хаах хугацаанд амьдрах, ажиллах нөхцөлийг сайжруулах, алба хаагчдын нийгмийн асуудалд анхаарах;

10.Энхийг дэмжих ажиллагаанд оролцох судалгаа, төлөвлөлтийг бодитой хийж, оролцоог нэмэгдүүлэхэд анхаарч ажиллах;

11.Улсын төсвийн зарцуулалтын үр ашигтай байдлыг дээшлүүлж, төсөв, хөрөнгө, материал, хэрэгслийн зарцуулалтад тавих хяналтыг сайжруулах, Зэвсэгт хүчнийг санхүүгийн чадавхын хувьд бэхжүүлэх арга хэмжээг хэрэгжүүлж, бүтээн байгуулалтаас хуримтлал үүсгэх;

12.Төрийн алба хаагчаас хууль хэрэгжүүлэх, сахилга хариуцлагатай байх, өөрийн хариуцсан албан үүргээ хариуцлагатай хашихыг өнөөгийн нийгэм, төр, засгийн удирдлагаас шаардах болсон. Иймд төрийн албаны болон цэргийн албаны хэм хэмжээ, ёс зүйн шаардлагыг бүх шатанд мөрдүүлж, цэргийн албаны болон цэргийн албаны хэм хэмжээ, ёс зүйтэй байж албаны хариуцлагыг чангатгах;

Үүний тулд:
-Шударга байх;
-бүх асуудлыг хуулийн дагуу шийдвэрлэдэг байх;

-ажлын байран дээр архи, согтууруулах ундаа хэрэглэх явдлыг таслан зогсоох, хатуу хариуцлага тооцох;

-гэмт хэрэг, зөрчил, хөдөлгөөний аюулгүй байдлын асуудалд анхаарах;

-нэгтгэл, ангиудын бие

бүрэлдэхүүний хандлагыг

өөрчлөх, нийгмийн өөрчлөлттэй

хөл нийлэх, сэтгэлгээний

өөрчлөлт хийх.

13.Сурталчилгаа, мэдээллийн

ажилд онцгой анхаарал

хандуулах, үүний тулд өндөр

мэдрэмжтэй байх, дэвшүүлсэн

бодлого, зорилт, хэрэгжүүлсэн

ажлын үр дүн, үйл ажиллагааг

иргэд, олон нийт, цэргийн алба

хаагчдад шуурхай мэдээлэх

ажлыг эрчимжүүлэх;

14.Дэлхий дахиныг

хамарсан цар тахлын онцгой

нөхцөл байдалд зохицож

ажиллах, үүрэг гүйцэтгэх бэлэн

байдлыг алдагдуулахгүйгээр

шаардлагатай хорио,

цэргийн дэглэм, ариутгал,

халдваргүйжүүлэлтийн горимыг

чанд сахих;

15.Ирэх 2021 онд олон

тэгш ой тохионо. Шинэ үеийн

Батлан хамгаалах яам үүсэн

байгуулагдсаны 110, орчин

цагийн Зэвсэгт хүчний 100

жилийн ойд бэлтгэх, тэмдэглэн

өнгөрүүлэх арга хэмжээг

салбарын хэмжээнд нэгдсэн

төлөвлөлтөөр зохицуулж, олон

улс болон үндэсний хэмжээнд

Батлан хамгаалах салбар,

Зэвсэгт хүчний түүхэн ололт,

амжилтыг сурталчлан таниулах,

Зэвсэгт хүчний дунд хугацааны

хөгжлийн хөтөлбөрийн эхний

шатны хэрэгжилтийг хангаж,

тодорхой үр дүнд хүрсэн байх.

Эцэст нь Батлан

хамгаалахын сайд Г.Сайханбаяр

батлан хамгаалах бодлогын

зорилт, үйл ажиллагааг

хэрэгжүүлэхэд бүх шатны

удирдлага, нийт алба хаагчдын

санаачилгаа, хичээл зүтгэлийн

хүчинд бодит үр дүнд хүрэн

гэдэгт итгэл төгс байгаагаа

илэрхийллээ.

ДУГААРЫН СУРВАЛЖИЛГА

БҮТЭЭН БАЙГУУЛАЛТ СҮНДЭРЛЭСЭН ЗАМААР...

Монгол Улсын Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний Ерөнхий командлагч Х.Баттулга 8 дугаар сарын 8-10-ны өдрүүдэд Дорноговь, Дундговь, Өмнөговь аймагт ажиллахын зэрэгцээ Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтын ажлын явцтай танилцаж, зарим офицер, ахлагч, ажилтан албан хаагчдад ажлын талбар дээр нь очиж шагнаж урамшуулав. Монгол Улсын Ерөнхийлөгчийг Зэвсэгт хүчний 336, 167 дугаар ангийн Хүндэт харуул болон Зэвсэгт хүчний Үлгэр жишээ, үлээвэр найрал хөгжмийн бүрэлдэхүүн ёслол төгөлдөр угтан авсан бөгөөд түүнийг дагалдаж Засгийн газрын гишүүн, Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр, Зэвсэгт хүчний Жанжин штабын дарга, хошууч генерал Д.Ганзориг, БХЯ-ны БХЗГ-ын дарга, хурандаа Х.Батсайхан, Зэвсэгт хүчний Хуурай замын цэргийн штабын дарга, бригадын генерал Л.Онцгойбаяр нарын албаны хүмүүс ажилласан юм.

Ингээд Их говийн гарнизон болон улс орныхоо бүтээн байгуулалтад манлайлан оролцож байгаа зарим бүрэлдэхүүнээ онцолъё. Зэвсэгт хүчний 336 дугаар ангийнхан хамт олны хүчин чармайлтаар нэлээдгүй бүтээн байгуулалтын ажлыг өрнүүлсэн байх агаад түүний нэг нь эмнэлгийн байр байв. ЗХЖШ-ын Бүтээн байгуулалтын дэмжлэгийн газар, орон нутгийн удирдлагын дэмжлэгээр өөрийн хүчээр эмнэлгийн байраа саяхан бүрэн шинэчилсэн байна. Одоо зөвхөн тохижуулах ажил үлдээд байгаа, шинэчлээд авна гэдэг л хамгийн чухал юм гэж ангийн эмч, сувилагч, асрагч бүсгүйчүүд онцолж байсан юм. Энэ өдөр ээлжийн сувилагчаар Г.Уянга гэдэг бүсгүй гарч байв. Тэрээр хань, ахлагч О.Санчирдоржоо дагаад Дорноговь аймагт ирсэн гэнэ. Одоогоор түүний хань БНӨСУ-д үүрэг гүйцэтгэхээр үзлэг, шалгалтад орох гэж Улаанбаатар хотыг зорьжээ. Тэд хоёр охинтой. Охиддоо Эрдэнэсувд, Сувд-Эрдэнэ гэдэг нэр хайрласан, хоёр талын аав, ээж нь нутаг орондоо ажилсаг, хөдөлмөрчөөрөө алдартай малчин буурлууд байдаг талаар ч хуучлав.

Залгуулаад цэргийн гал тогоогоор орлоо. Ээлжийн тогооч Н.Одончимэг тэргүүтэй бүсгүйчүүд цэргүүдийн өдрийн хоолыг хийгээд тун завгүй байж таарав. Зэвсэгт хүчиндээ 13 дахь жилдээ алба хааж байгаа Н.Одончимэг "Манай бүсгүйчүүд сэтгэлээ шингээсэн, шим тэжээлтэй хоол, хүнсээр хүүхдүүдээ дайлдаг" хэмээн ярилцлагын эхэнд онцлов. Цэргийн анги бол түүний хоёр дахь гэр, амьдралынх нь 13 жилийн жаргал, зовлонгийн алинд ч хамт яваа хамт олондоо

замын бүтээн байгуулалтын ажилд хүчин зүтгээд завгүй гэнэ. Тэд гурван охин, нэг хүүтэй. Хоёул ажил ихтэй байдаг ч том охин А.Номин-Эрдэнэ дүү нараа асраад сурчихсан, хоол хүртэл хийж өгдөг



болчихсоныг ээж нь бахархан хуучилж байлаа. Анх цэргийн амьдралыг төдийлөн ойлгодоггүй, хөндлөн мэт санагддаг байсан ч нэг жилийн өмнөөс энэхүү хамт олны дунд ороод хамгийн ихээр ойлгодог болж, цэрэг дайчдыг бахархахгүй байхын аргагүй хүмүүс гэдгийг мэдэрсэн гэв.

Түүний адил ханиа дагаад Зүүнбаянд ирсэн өөр нэг бүсгүй бол бэлтгэгч Ү.Гэрэлбат, үйлчлэгч А.Саруулцэцэг нар. Ү.Гэрэлбат "Цэргийн хоол бэлтгэх нь их буянтай ажил. Манай гал тогоонхон "Баярлалаа" гэдэг үгэнд ихэд урамшдаг, хэн нэгнээ гэсэн сэтгэл дүүрэн эвсэг бүсгүйчүүд" гэж онцолж байсан бол А.Саруулцэцэг ханиа дагаад Булган аймгаас ирсэн гэнэ. Түүний хань ахлагч Ч.Эрдэнэбаатар Зэвсэгт хүчний 234 дүгээр ангиас томилогдож ирсэн бөгөөд хангай нутгаас халуун говьд ирэхэд анх хэцүү мэт санагдаж байсан ч одоо дассан аж.

Үргэлжлүүлээд Өмнөговь аймгийн Цогтцэций, Манлай сум, Дорноговь аймгийн Мандах, Сайншанд сумын Зүүнбаян багийн нутаг дэвсгэрийг хамран 414.6 км урт төмөр замын далангийн суурь бүтэц, гүүр хоолой, нэг өртөө, зургаан зөрлөгийг зарим хувийн хэвшлийн компани, төмөр замчдын хамт барьж байгуулж байгаа дайчид дээр очив. Монгол Улсын Ерөнхийлөгч бүтээн байгуулагч залуусыг "Эх орныхоо бахархал болсон залуус, шинэ цагийн түүх бүтээж байгаа та бүхэн энэ улсад гавьяатай хүмүүс шүү" хэмээн онцолж байсныг дурдах нь зүйтэй байх.

Хурандаа Ц.Амарсайхан захирагчтай Зэвсэгт хүчний 110 дугаар ангийнхан саяхандаа л "Зөрлөг III"-ийн ажилчдын

ангийн барилгачин дайчидтай хамтран богино хугацаанд чанарын өндөр түвшинд барьж ашиглалтад оруулсныг манай цэргийнхэн мэдэх байх аа" гэв.

Яг энэ үед тус ангийнхан

ажил 99 хувьтай байгаа ажээ. Төмрөн бетон гүүрийг барьж байгаа залуус дээр очлоо. Энэхүү төмрөн бетон гүүр нь Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн 414.6 км зам дагуух гүүрнүүдээс хамгийн урт

нь гэнэ. Тус ангид 14 хоногийн өмнө Зэвсэгт хүчний 330 дугаар ангийн 10 цэргийн алба хаагч хүч нэмэгдүүлэн ирсэн байна. Оны эхэнд "Зэвсэгт хүчний ахлагчийн албыг хөгжүүлэх хөтөлбөр-2021"-ийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны харьяа Говьсүмбэр аймаг дахь Политехникийн коллеж, Налайх дүүрэг дэх Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвд хүнд машин механизмын оператор, хүнд машин механизмын засварчин, гагнуурчин, зам гүүрийн мэргэжилтэн, тогооч гэсэн таван тусгай мэргэжлээр 180 гаруй цэргийн гэрээт болон хугацаат цэргийн алба хаагчид суралцан төгссөн бөгөөд тэд өдгөө ажлын талбар дээр мэргэжлийнхээ дагуу ажиллаж байгаагаар ч таарав. Тухайлбал, дэд ахлагч М.Эрдэнэбилэг тэдний нэг ажээ. Тэрээр арматурын бэлдцийг хийж сурсан, барилгын өрлөгийг ч хийж дадсан байна. "Ах нараасаа их зүйлийг сурч байна. Эзгүй талаар өөрсдийн бүтээн байгуулсан төмөр замаар галт тэргэнд суугаад явах цаг удахгүй байх аа. Тэр үед өөрөөрөө болон цэргийн ах, эгч нараараа бахархах байх аа. Бидний хөдөлмөр энэ цаг үед хүч, хөлс шавхаж байгаа ч ирэх цагийн бахархал нь байх болно. Цэргийнхний хүчээр энэ зам сүндэрлэж байна. Ажил үйлс ундарч, залуус урамтай байгаа" гэв.

Тус ангийн зарим офицер, ахлагч, ажилтан албан хаагчдад Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулга Төрийн дээд одон, медаль хүртээж, баяр хүргэсэн ба Хөдөлмөрийн хүндэт медалиар энгэрээ мялаалгасан В.Октябрьтой хөөрөлдөв. Тэрээр "Ажлын талбар дээрээ хөдөлмөрөө үнэлүүлэх сайхан юм байна. Хамт олондоо маш их баярлалаа. Эхнэртээ хэлэхэд баярлаад л байсан" гэв.

2019 оны 12 дугаар сард өвлийн тэсгим хүйтэнд гүүр хоолой барьж буй бүтээн байгуулагч дайчдад халуун аарц зөөж гүйсэн сувилагч бүсгүй, ахлагч Б.Золжаргалтай ч дахин таарлаа. Тэр үед "Эмч болох мөрөөдөлтэй. Их эмчээр суралцаж байгаа" гэж ярилцлага өгч байсан бол энэ жил сургуулиа төгсөж их эмч хэмээх алдрын эзэн болж чаджээ. Бүтээн байгуулалтын шан тавихаас нь эхэлж оролцож яваа энэ бүсгүй Зэвсэгт хүчинд тав дахь жилдээ алба хааж байгаа, хамт олноо өвчин эмгэгээс урьдчилан сэргийлэх нь түүний гол зорилго аж.

Дэд хурандаа Д.Зоригтсайхан захирагчтай Зэвсэгт хүчний 7780 дугаар ангийнхан ч ялгаагүй ажлын талбар дээрээ бужигнаад, ангийн байрлалд тогооч, сувилагчаас өөр хүн алга. Хамгийн сонирхолтой нь тус ангийнхан ШБОС буюу шинэ бүтээл, оновчтой санаа шингэсэн нэгэн шинэ техник "бүтээсэн" нь бульдозер машины ард индүүдэгчийг орлох томоохон труба холбож, цаг, мөнгө, хүн хүч хэмнэж чадсан байна. Өөрөөр хэлбэл, бульдозер машины урд талын хэсэг нь бланс чулууг

тарааж байхад арын хүнд даацын труба нь үргэлжлүүлээд индүүдээд явчихдаг юм байна. Энэхүү шинэ "бүтээл"-ийг Хуурай замын цэргийн штабын дарга, бригадын генерал Л.Онцгойбаяр үзэж сонирхоод, бүтээсэн алба хаагчдад нь баяр хүргэж байлаа.

Дэдхурандаа Д.Зоригтсайханы хэлснээр тус ангийнхны хувьд төмөр замын суурь далангийн ажлын явц 100, хоолойн ажил 97, төмөр замын дээд бүтцийн ажил буюу бланс дэвсгэлт 26 хувьтай байгаа. Үүнээс гадна хамгийн сайхан мэдээ нь цэргийнхэн төмөр замын суурь далангийн ажил, гүүр, хоолой, өртөө, зөрлөгийн барилгуудыг барьж байсан бол өдгөө дээд бүтцийн ажил болох төмөр замын рейльс угсрах ажилд ханцуй шамлан орцгоожээ. Өдгөө 1 километр гаруй зам тавьсан байх агаад өдөрт дунджаар 100-150 метр орчим төмөр замын рейльс угсардаг байна. Энэ нь маш их хэмжилт хийдэгтэй холбоотой аж. Тиймээс төмөр замын рейльс угсарч буй цэргийнхэн дээр очлоо. 20 гаруй залуус дор бүрнээ завгүй, рейльс төмрийг тусгай тоног төхөөрөмжөөр хэмжиж, ёстой нэг төв, төгөөр нь шахам суурилуулж байна. Төмөр замын хяналтын багийн хоёр залуу ч бас хянаад зогсож байв. Тэдний нэг замчин Н.Отгонбаяр "Цэргийнхэн их хариуцлагатай. Ялангуяа 7780 дугаар ангийнхан механикжсан анги гэдэг утгаараа бүтээмж өндөр. Ажилдаа гаршсан хамт олон, төмөр замчин бидний заавар, зөвлөмжийг ч их сайн мөрддөг" гэж хяналтын багийнхан магтахад нь цэргийнхнийхээ өмнөөс баярлах мэт ихэд сайхан сонсогдов.

Зэвсэгт хүчинд цэргийн алба хаагчаас дутахааргүй үүрэг, хариуцлага хүлээн ажлын голыг нь нугалж, ачааны хүндийг үүрдэг олон энгийн ажилтан байдаг жишгээр бүтээн байгуулалтын талбайд ч бас ажиллаар л байна. Тухайлбал, гал тогоонд тогооч Г.Гүндэгмаа (256), бэлтгэгч Б.Гүндэгмаа (326), Ц.Чинбат (014) нар бүрэлдэхүүнийхээ оройн хоолыг хийж байв. Хоёр "амьдаа"-г хамт олон нь овгийнх нь үсгээр л ялгаж дууддаг гэнэ. Г.Гүндэгмаа нь Зэвсэгт хүчинд 14, Ц.Чинбат нь найм, Б.Гүндэгмаа гурав дахь жилдээ алба хааж байгаа бүсгүйчүүд байна. Тэд долоо хоногт төрөл давтагдахгүйгээр хоол хийж өгдөг, бүрэлдэхүүн ч хоол, ундандаа ам сайтай байдаг нь тэдний урам зориг, эрч хүч нь болдог гэнэ лээ.

Эмнэлгийн байраар ч оров. Ахлагч П.Болорцэцэг (189), С.Шаргаа (186) нар энэ долоо хоногт хийхээр төлөвлөсөн ажлаа жагсаагаад сууж байна. Эмнэлэгт нь эм, тариа, ороох боох материал, шарлага, бумба тавих тусгай багаж хэрэгслүүд нь дүүрэн. Ахлагч П.Болорцэцэг "Алба хаагчдаа өдөр тутамд үзлэг явуулдаг. Өвлийн улиралд ханиад, зуны улиралд нар, шарилж, шороо тоосноос үүдэлтэй харшил тусах тохиолдол элбэг байгаа. Гэхдээ бид аль болох даамжирч, хүндрэхээс нь өмнө эмчилж анагааж байгаа" гэв. Харин С.Шаргаа хэмээх бүсгүй "Энэ их бүтээн байгуулалтыг нугалах залуус нэн тэргүүнд эрүүл мөн тус ангид ажилласан бөгөөд "Ажил сайн явагдаж байна" хэмээн урамшуулаад сургагч ахлагч Мөнхсайхан (110), ахлагч Дэлгэрсайхан (336) нарт Цэргийн хүндэт медаль, Мөнхжаргал (014)-д Хөдөлмөрийн хүндэт медаль хүртээсэн юм.

Төгсгөлд нь тус ангийн Бутлуурын үйлдвэрт очив. Үйлдвэрийн дарга, ахмад К.Аймурат хэлэхдээ "Манай үйлдвэр хэрэгцээтэй материалуудыг Зэвсэгт хүчний ангиудад нийлүүлж байна. Ажлын явц 70 хувьтай. Нийгмийн хариуцлагын хүрээнд Өмнөговь аймгийн Манлай сумын цэцэрлэгт хүрээлэн, биеийн тамирын талбайд хайрга нийлүүлсэн" гэдгийг онцлов.

Тийм ээ. Торойх зүйлгүй тал нутагт цэргийнхэн болон хувийн хэвшлийн барилгачид, төмөр замчдын их бүтээн байгуулалт цаашид ч сүндэрлэнэ.



хайртай гэдгээ ч илэрхийлж байсан юм. Харин бэлтгэгч-тогооч Б.Сумъяа офицерын гэргий бөгөөд мөн л ханиа дагаад "Их говийн гарнизон"-д хоёр жилийн өмнө иржээ. Сүхбаатар аймгийн Дарьганга сумын харьяат энэ бүсгүй хань, ахлах дэслэгч А.Алтанхуягаар маш их бахархдаг нь андашгүй байв. Түүний хань 2017 онд "Ирээд л үз" гэрэл зургийн үзэсгэлэнгээ Улаанбаатар хотод гаргаж байсан, өдгөө төмөр

орон сууц, удирдлагын байрыг барьж эхлүүлж байсан бол өдгөө хэдийнээ сүндэрлүүлжээ. Тус ангийн гүүр хоолойн бүлгийн дарга, ахмад М.Эрдэнэбулган хэлэхдээ "Манай анги 28 гүүр хоолойгоо бариад дууссан, одоо зөвхөн бэхлэлгээ хийж байна. Энэхүү барилгын явц 80 гаруй хувьтай байна. Зарим нөхөд өртөөний барилга барьж байгаа. "Зөрлөг VI"-ийн орон сууц, удирдлагын байрыг Зэвсэгт хүчний 339 дүгээр

байсан юм.

Хурандаа Б.Дорждэрэм захирагчтай Зэвсэгт хүчний 017 дугаар ангийнхан торойх бараагүй тал нутагт мөн л бүтээн байгуулалтыг ид өрнүүлж байна. Хурандаагийн хэлснээр тус ангийнхан гүүр, хоолой, орон сууц, өртөөний барилга гээд дөрвөн газарт хуваагдан ажиллаж байгаа гэнэ. Төмрөн бетон гүүрийн ажил 60, барилгын ажил 80, өртөөний бүтээн байгуулалт 30, хоолойн

ДУГААРЫН СУРВАЛЖИЛГА

ТЭД ТЕХНИКИЙН БЭЛЭН БАЙДЛЫГ ДЭЭШЛҮҮЛЭХЭД ОНЦГОЙ АНХААРЧЭЭ

Зэвсэгт хүчний үүрэг гүйцэтгэх бэлэн байдлын салшгүй нэг хэсэг нь зэвсэглэл, техникийн бүрэн бүтэн байдал, ашиглалт, хадгалалт, арчлан хамгаалалт юм. Тиймээс Зэвсэгт хүчний нэгтгэл, ангиуд үүрэг гүйцэтгэх бэлэн байдлаа хангахын тулд өдөр тутамд өөрсдийн зэвсэглэл, техниктээ үзлэг, засвар, үйлчилгээ хийж, байнгын анхаарал хандуулдаг. Гэхдээ удаан хугацаанд хадгалагдаж байгаа техникүүдээ гар хүрч, үүрэг гүйцэтгэх боломжийг нь дээшлүүлэх талд анхаарч байгаа анги, нэгтгэл тийм ч олон биш. Аливаа техник хэрэгслийг засаж, сайжруулна гэдэг нь ардаа чамгүй их төсөв, хөрөнгө шаардсан ажил байдаг болохоор ангиуд тэр бүр энэ ажил руу ороод байдаггүй. Тэгээд ч энэ талын ажлыг зохион байгуулах хангалттай санхүүжилт нь Зэвсэгт хүчний төсөвт суудаггүй гэдгийг уншигч та сайн мэднэ биз ээ.

"Түнэр харанхуйг зүхэж суухаар ядаж ганц ч гэсэн лаа асаа" хэмээх зүйр үг бий. Үүнтэй агаар нэг "Боломжгүй гэж шалтаг тоочилгүй" гээр техникүүдийнхээ бэлэн байдлыг дээшлүүлж, засвар үйлчилгээ хийж байгаа хамт олон байна. Тэд бол Зэвсэгт хүчний 327 дугаар анги юм. Тус ангийн удирдлагаас "Нэг сар-нэг техник" аяныг зохион байгуулж, удаан хугацаанд хадгалагдаж байгаа техникүүдээсээ 30 гаруй авто

машиныг сэргээн засах болзолт уралдааныг бие бүрэлдэхүүнийхээ дунд зарласан юм. Энэхүү аяны хүрээнд засагдаж, үүрэг гүйцэтгэхэд бэлэн болсон авто машинуудыг үзэж үнэлгээ, дүгнэлт өгөхөөр ЗХЖШ-ын Ар талын газрын Техникийн хангалтын хэлтсийн дарга, хурандаа Ц.Төрмөнх, хэлтсийн мэргэжилтэн, дэд хурандаа Д.Мөнхбаатар, Зэвсэгт хүчний авто техникийн хяналтын албаны дарга, цагдаагийн хурандаа Л.Баярцогт, Зэвсэгт хүчний Хуурай замын цэргийн командлалын Материал, техникийн хэлтсийн ахлах офицер, дэд хурандаа Ж.Банзрагч нарын комисс тус ангид ажиллалаа.

Зэвсэгт хүчний 327 дугаар ангийн бүх алба, нэгж, тасгууд "Нэг сар-нэг техник" аянд хамрагдсан бөгөөд тэд өөрсдийн засаж, үйлчилгээ хийсэн авто техникүүдийн бэлэн байдлыг шалгуулахаар комиссыг очиход эгнэн жагссан байлаа. Үнэхээр гаднаас нь харахад яг л шинэ юм шиг харагдаж байсан тэдгээр авто машинуудад аккумулятор холбоход л хөдөлгүүр нь шууд асаж, үүрэг гүйцэтгэхэд бэлэн болохоо харуулсан юм. Энэ үеэр хурандаа Ц.Төрмөнх "Сүүлийн жилүүдэд Зэвсэгт хүчний ангиуд тохижилт, бүтээн байгуулалтын ажлуудыг ихээр хийж болсон. Мэдээж бие бүрэлдэхүүний ая тухтай орчинд ажиллаж, үүргээ



гүйцэтгэхэд энэ талын ажил чухал ч гэлээ, Зэвсэгт хүчний бэлэн байдлыг дээшлүүлэхэд анхаарч ангид аяны өргөн хүрээг хамарсан ажил хийсэн анги одоогоор Зэвсэгт хүчний 327 дугаар ангиас өөр алга гэж хэлж болно. Гар, сэтгэл нийлбэл юу хийж болдгийг тус ангийн залуус харуулаа. Авто машин бүрийг ингэж шинэ мэт болтол нь засаж, үйлчилгээ хийнэ гэдэг бол маш их ажил. Хийсэн ажлаараа Зэвсэгт хүчний ангиуддаа үлгэр дуурайлал болсон

та бүхэнд амжилт хүсье. Цаашдаа бусад ангиуд ч энэхүү өндөр ач холбогдолтой ажлыг олноор нь зохион байгуулаасай гэж уриалж байна" гэсэн юм. Харин Зэвсэгт хүчний 327 дугаар ангийн захирагч, дэд хурандаа Т.Тогмиддүүмий "Ангийн удирдлагаас анх уг ажлыг санаачилж байхдаа ийм өргөн хүрээг хамарсан том ажил болно гэж төсөөлөөгүй. Бие бүрэлдэхүүн маань оногдсон техникээ сэргээн сайжруулахын тулд маш их сэтгэл

гаргаж ажилласан. Энэ бол дан ганц манай ангийн бэлэн байдалтай холбоотой асуудал биш цаашлаад Зэвсэгт хүчний техникийн бэлэн байдлыг дээшлүүлэхэд ийм гарц, шийдэл байж болох юм гэсэн санааг бусад ангийн бие бүрэлдэхүүнд өгч байгаа юм" гэв.

Ингээд удаан хугацаанд хадгалагдаж байгаа авто техникүүдэд засвар хийсэн зарим албан тушаалтны сэтгэгдлээс хүргэе.

ЗАСВАРЛАСАН АВТО МАШИНАА ХАРАХААР УРАМ ОРЖ БАЙНА

Соёл хүмүүжлийн албаны дарга, ахмад Д.ГАНБААТАР:

-Би 2012 онд ҮБХИС-ийг Соёл хүмүүжлийн офицер мэргэжлээр төгсөөд тус ангид салааны захирагч, ротын ажиллагааны офицер, мотобуудлагын батальоны ажиллагааны офицороор ажиллаж байгаад энэ оны эхнээс соёл хүмүүжлийн албаны даргын албан тушаалд томилогдоод ажиллаж байна. Эхнэр маань аймгийн Хаан банкны салбарт хүний нөөцийн албанд ажилладаг. Зэвсэгт хүчин, цэрэг, армийн баялаг түүхтэй Дорнод аймгаас ажлын гараагаа эхэлсэндээ баяртай байгаа. Ер нь манай анги Зэвсэгт хүчиндээ шинэ, шинэ ажлуудыг санаачлан өрнүүлж чаддаг. Учир нь бие бүрэлдэхүүний дийлэнх хувийг залуу боловсон хүчин эзэлдэг болохоор бид үргэлж шинийг санаачлахыг зорьдог.

"Нэг сар-нэг техник" аяны хүрээнд манай хорооны удирдлагууд маш зоригтойгоор өргөн далайцтай ажлыг эхлүүлж чадлаа. Бусад Зэвсэгт хүчний ангиудад ингэж олноор нь техникээ сэргээн засварласан удаа байхгүй гэж бодож байна. Зориглоод хийвэл ямар ч ажлын ард гарч болдгийг манай ангийн удирдлага, хамт олон харууллаа. Бусад ангиуд ч үүнээс санаа аваад цаашид энэ мэт ажлыг хэрэгжүүлээсэй. Үүрэг гүйцэтгэх бэлэн байдалд хамгийн чухал үүрэгтэй нь техник, хэрэгсэл гэдгийг бүгд мэддэг ч ийм ажил төдийлөн хийгдээд байдаггүй. Ангийнхан ч үүнийг бүгд ухамсарлаж, сэтгэлээ шингээн ажилласан нь эндээс харагдаж байгаа гэдэгт итгэлтэй байна.

Тус ангийн соёл хүмүүжлийн албаны хувьд бүрэлдэхүүнийхээ дунд хурал зарлаж, тодорхой эд ангиудын жагсаалтыг гарган төсвийг бүрдүүлснээр засварын ажлаа



эхлүүлсэн. Авто машинуудын кузов болон явах эд ангиуд нь зэвд идэгдсэн. Мөн нэг машины мотор нь ажиллагаагүй байсан тул бид шинээр боож, засварласан. Эрэг боолтууд нь он удаан жилийн хадгалалтын улмаас чангарахаа больсны дээр урд чагтан гол нь эвдэрсэн байсныг нь шинээр сольж тавьсан гээд хийсэн ажил их. Ямар ч байсан одоо зассан авто машинаа харахаар урам ороод манай бүрэлдэхүүн ч сэтгэл өндөр байгаа.

БҮХ ЭД АНГИУДЫГ ШИНЭЭР ХУДАЛДАЖ АВСАН



Артиллерийн дивизионы зэвсэглэл, техник хариуцсан офицер, дэслэгч Ж.САРУУЛ:

-Би 2011-2015 онд ҮБХИС-д суралцаж авто инженер мэргэжлээр төгссөн. Тиймдээ ч тус аян миний үндсэн мэргэжлийн онцлогийг сэргээсэн,

мэдлэг, дадлага нэмсэн сайхан ажил боллоо. Цаг үеэ олсон үр дүнтэй ажлыг санаачилж зохион байгуулсан ангийнхаа удирдлагад талархсанаа илэрхийлье.

Тус дивизионоос олон тооны офицер, ахлагч нар хамрагдаж нэг сарын хугацаанд дөрвөн нэгж техник сэргээн засварлах ажлыг гүйцэтгэсэн. Тодруулбал, 1997 оноос хойш хөдлөөгүй удаан хугацааны хадгалалтад байсан техникүүдийг сэргээн засварлалаа. Цаашдаа энэ ажлыг уламжлал болгон жил бүр зохион байгуулбал ангийн бэлэн байдал тэр чинээгээрээ дээшилнэ гэж бодож байна. Энэ ажлын хүрээнд явах эд анги, хагарсан дугуй, хөдөлгүүрийн редуктор зэргийг шинээр сольж тавьсан. Удаан хугацааны хадгалалтаас гарахдаа бүх жийрэг резинүүд нь хагарч муудсан, сэтэрсэн, тос масло нь холилдсон байсан. Тиймээс шинэ эд ангиудыг бүгдийг нь зах зээлээс худалдаж авсан. Манай засварын бүлэг дөрвөн нэгж техник дээрээ ажиллаж байхад үлдсэн бүрэлдэхүүн ажлын бус цагаар гэрээт ажил гүйцэтгэж түүнээс олсон орлогыг засварын ажилдаа зориулсан нь үр дүнгээ өгсөн.



эвдэрч, ашиглагдахаа больсон, радиаторууд нь сэтэрч, ус хийхээр гоождог, бүх дугуйнууд нь хагарч, нөөц дугуйнууд нь үүрэг гүйцэтгэх боломжгүй болсон байсан. Энэ бүгдийг албаныхаа сэтгэл, зорилго нийлсэн бүрэлдэхүүнийхээ хүчээр шинээр сэлбэн засаж, Улаанбаатар хотоос шаардлагатай эд ангиудыг захиалан авчруулснаар амжилтад хүрлээ.

ЗАЛУУС МААНЬ АЛИВАА АЖЛЫГ ХУРДАН, ШУУРХАЙ ГҮЙЦЭТГЭДЭГ



Холбооны зангилгааны дарга, хошууч Ц.НОМИНЗУЛ:

-Би 20 дахь жилдээ Зэвсэгт хүчинд алба хааж байна. БХИС-ийг цахилгаан холбооны инженер мэргэжлээр төгсөөд 2004-2008 онд тус ангид мөн 2008-2012 онд Зэвсэгт хүчний 326 дугаар ангид ажилласан. Улмаар 2012 оноос тус ангидаа эргэн томилогдоод ажиллаж байна. Энэ хугацаанд холбоо салааны захирагч, холбооны инженер, мэдээллийн аюулгүй байдлын офицер, хүний нөөцийн офицер зэрэг албан тушаалыг хашиж байсан.

Урд өмнө нь төдийлөн анги, байгууллагуудад явагдаж байгаагүй аяныг манай хамт олон эхлүүлээ. Цаашид бусад салбарын техник хэрэгслийг сэргээн засварлавал үр дүнтэй юм байна гэж бодсон. Миний хувьд холбооныхоо техник хэрэгслийг л мэднэ үү гэхээс авто машины, тэр тусмаа ОХУ-д үйлдвэрлэсэн авто техникийн талаар ойлголт тааруу байсан. Гэтэл "Нэг сар-нэг техник" аянд оролцоод авто машины талаар нэлээд мэдлэг, дадлагатай болоод авлаа. Тиймээс дараагийн удаа өөр салбарын техник, хэрэгслийг сэргээн засварлах аваас бусад бүрэлдэхүүн

ч миний нэгэн адил бусад техникийн талаарх мэдлэг, дадлагатай болно.

Манай албаны хувьд авто машинуудаа хүлээж аваад бүх эвдрэл, гэмтэл, шаардлагатай эд ангиудын жагсаалтыг гаргаж, гурван техникээ засах бүлгүүдийг томилсон. Анх явах эд анги нь бүтэн зэвэрсэн, өнгө зүссээ алдсан, бүх дугуй нь хагарсан байдалтай байсан. Бид шаардлагатай бүх эд ангиудыг худалдаж авсан. Мөн салонд доторлогоо хийж, анхааруулах таних тэмдэг, тэмдэглэгээ, гэрэл цацруулагч зэргийг шинээр суурилууллаа. Мэдээж бүх авто машинуудыг бүрэн будганд оруулсан.

Ер нь тус ангийн бие бүрэлдэхүүн нь залуучуудаас бүрддэг учир гар, сэтгэл нийлэн ажиллахад амар байдаг. Тиймээс ямар ч ажил даалгасан залуус маань хурдан шуурхай гүйцэтгэж чаддаг. Ангийн удирдлагаас бүрэлдэхүүнийг үндсэн үүргээ мадаггүй гүйцэтгэхийг шаардахаас гадна бусад ажлын чиглэлээр олон зүйлийг санаачлан өрнүүлж, ангийн үүрэг гүйцэтгэх бэлэн байдал, өнгө үзэмжийг сайжруулах талд онцгой анхаарч ажилладаг гэдгийг энд онцлон хэлье.

ЭНЭ АНГИГҮЙГЭЭР ӨӨРИЙГӨӨ ТӨСӨӨЛӨХИЙН АРГАГҮЙ

албан тушаалд дэвшин ажиллаж байна. Миний хувьд мотобуудлагын тусгай хороонд ажиллаж, амьдарч байгаадаа үргэлж баяртай явдаг. Анх 19 настай тус ангийн босгоор алхаж байснаас өнөөдрийг хүртэл амьдралын минь бүхий л сайн сайхан дурсамжууд гагцхүү энэ л ангитай холбогджээ. Өөрөөр хэлбэл энэ ангигүйгээр өөрийгөө төсөөлөхийн аргагүй болсон гэсэн үг.

"Нэг сар-нэг техник" аяны хүрээнд манай ангийн залуус өмнөө нэг зорилго тавьж, түүнийхээ ард амжилттай гарлаа. Гар, сэтгэл нийлбэл хүмүүс ямар ч ажлыг хийж болдог гэдгийг харуулсан байх гэж бодож байна. Би ч өөрийнхөө техниктэй сайн "ноцолдоод" авлаа. Бараг л авто машинтайгаа ярилцах нь холгүй л өдрийг хамт өнгөрүүлээ. Цаашдаа энэхүү ажлыг анги бүр дотооддоо зохион байгуулаасай.

Нүүрийг бэлтгэсэн ахлах дэслэгч М.МӨНХЗОРИГ

“МОНГОЛ ЦЭРГИЙН НЭГДСЭН ХОЛБОО”-НЫ САЛБАР БАРУУН ХЯЗГААРТ БАЙГУУЛАГДАВ

“Монгол цэргийн нэгдсэн холбоо” ТББ салбар холбоодоо Архангай, Баянхонгор, Говь-Алтай, Дархан-Уул, Дорноговь,

байгууллагуудын гүйцэтгэдэг хүндтэй бөгөөд хариуцлагатай хөдөлмөрийг нийгэмд таниулан сурталчлах үйлсэд “Монгол

Тухайлбал, “Монгол цэргийн нэгдсэн холбоо” ТББ нь салбар холбоодын тэргүүнүүд, нарийн бичгийн дарга нартай арга зүйн



Төрийн есөн хөлт цагаан тугийн өмнө

Дорнод, Орхон, Өвөрхангай, Өмнөговь, Сүхбаатар, Сэлэнгэ, Хөвсгөл, Хэнтий зэрэг 15 аймагт байгуулаад байсан бол өнгөрсөн сард энэ тоо нэгээр нэмэгдэж, Увс аймагт тус холбооны салбар байгуулагдажээ.

Тодруулбал, 2020 оны 7 дугаар сарын 25-ны өдөр салбар холбоо байгуулагдаж, нэгдсэн холбооноос анхдугаар хурлыг зохион байгуулж, удирдах албаны хүмүүсээ сонгожээ. Салбар холбооны даргаар Увс аймгийн Засаг дарга Д.Батсайхан, нарийн бичгийн даргаар бэлтгэл хурандаа Я.Чулуунбаатар болон удирдах зөвлөлийн гишүүдийг сонгож томилсон байна.

Төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагаас тэтгэвэр, чөлөөнд гарсан ахмад дайчдаар дамжуулан иргэн-цэргийн харилцааг бэхжүүлж, эх орноо хамгаалах, хууль сахиулах, иргэдийн аюулгүй байдлыг хангах үүрэг бүхий

цэргийн нэгдсэн холбоо” чамлахааргүй амжилт гаргаад байна. Увс аймаг дахь салбар холбоо байгуулагдаад удаагүй ч нэгэн бахархалт үйл ажиллагааг санаачлан ажлын гараагаа эхлүүлжээ. Тодруулбал, тэд салбар холбоогоороо дамжуулан Чөлөөлөх дайны ялалтын 75 жилийн ойг угтаж 45 хүний бүрэлдэхүүнтэй тойрон аяллыг Увс-Улаанбаатар-Дорнод чиглэлд зохион байгуулж байна.

Аяллын хүрээнд тэд Монгол цэргийн нэгдсэн холбооны үйл ажиллагаа, зорилго, зорилттой танилцаж, цаашид хэрэгжүүлэх үйл ажиллагааны талаар мэдээлэл авчээ. Энэ тухай салбар холбооны гишүүд хэлэхдээ “Бид нэгдсэн холбооныхоо үйл ажиллагаатай танилцаад тэдний хийж байгаа ажлын цар хүрээ, үр нөлөө асар их гэдгийг мэдэртээ. Мөн цаашид хэрэгжүүлэх ажлын талаар ч мэдээлэл авлаа.

сургалтыг зохион байгуулах, төрийн бус байгууллагууд болон мэргэжлийн холбоодтой хамтран сар бүр “Миний мэргэжил-эх орноо хамгаалагч” сэдэвт нийгэм, иргэдэд хандсан сурталчилгаа, соён гэгээрүүлэх ажлыг хэрэгжүүлэх, Монгол Улсын нийт энхийг сахиулагчдын чуулга уулзалтыг зохион байгуулах, төрийн болон орон нутгийн байгууллагуудтай хамтран төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх ажлыг эрчимжүүлэх, төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагуудын ахмадууд, алба хаагчдын эрдэм шинжилгээний бүтээл, номын нэгдсэн үзэсгэлэн гаргаж, номын баяр хийх зэрэг олон ажлыг төлөвлөж, эхнээсээ ажил хэрэг болгоод явж байгаа юм байна” гэв.

Ингээд Увс аймгийн “Монгол цэргийн нэгдсэн холбоо” ТББ-ын салбар холбооны зарим гишүүдийн сэтгэгдлээс хүргэе.



ЦДБЭЧ-ынхан уран бүтээлээсээ толилуулав



Тэд ЦДБЭЧ-ын тоглолтыг анх удаа үзсэндээ бахархаж байлаа



Г.К.Жуковын музейн үзмэрүүдийг үзэж байгаа нь

НУТАГТАА ОЧООД ОЛОН АЖЛЫГ ХЭРЭГЖҮҮЛНЭ

“Монгол цэргийн нэгдсэн холбоо” ТББ-ын Увс аймаг дахь салбар холбооны нарийн бичгийн дарга, бэлтгэл хурандаа Я.ЧУЛУУНБААТАР:

“Өнгөрсөн сард Увс аймагт “Монгол цэргийн нэгдсэн холбоо” ТББ-ын салбар байгуулагдаж, миний бие нарийн бичгийн даргаар сонгогдсон. Мөн удирдах зөвлөлийн гишүүдээ сонголоо. Манай аймагт төрийн цэргийн болон хууль сахиулах долоон байгууллага үйл ажиллагаа явуулдаг. Тэдгээрээс тэтгэвэр, чөлөөнд гарсан хүмүүсээс сонгож, 20 хүний бүрэлдэхүүнтэй удирдах зөвлөлийг байгуулсан. Манай байгууллага одоогоор хамгийн отгон нь ч гэсэн бидний хувьд ажлын гараагаа тун сайхан аяллаар эхлүүлж байгаадаа баяртай байна. Энэ аялалд удирдах зөвлөлийн арав гаруй хүн, сумдын багийн Засаг дарга нарын төлөөлөл, аймгийн төрийн цэргийн болон хууль



сахиулах байгууллагуудад ажил үйлсээрээ манлайлж байгаа залуус зэрэг 40 гаруй хүний бүрэлдэхүүн хамрагдаж байна. Бид Улаанбаатар хотод ирмэгцээ Монгол Улсын Төрийн ордонд орж, Есөн хөлт цагаан тугаасаа адис авсан. Мөн “Монгол цэргийн нэгдсэн холбоо” ТББ-д очиж, үйл ажиллагаатай нь танилцаж, Цэргийн Дуу Бүжгийн Эрдмийн

Чуулгын уран бүтээлчдийн бэлтгэсэн тоглолтыг үзэж сонирхсоны сацуу Г.К.Жуковын музейн үзмэртэй танилцлаа. Түүнчлэн Бүх цэргийн Их хар сүлдэндээ мөргөж, хийморио сэргээгээд ч амжсан.

Нэмж хэлэхэд, Зэвсэгт хүчээрээ омогшин бахархаж, ажил үйлсээр нь үлгэр дуурайлал авсан маш сайхан аялал болж байна. Эндээсээ бид Дорнод аймгийг зорьж, шинэ Халх гол сумын үйл ажиллагаатай танилцаж, байгалийн цогцолборт газруудыг үзэж сонирхоно. Цаашдаа нутаг орондоо очоод Зэвсэгт хүчний үйл ажиллагааг сурталчилсан олон ажлыг хэрэгжүүлнэ. Тухайлбал, холбооны үндсэн үүрэг болох хүүхэд, залуусыг цэрэг-эх оронч үзлээр хүмүүжүүлэх, алба хаагчдынхаа нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлэх зэрэг ажлыг төлөвлөн явуулах болно.

УВСААС БУЙР НУУР, БУЛАН ДЭРС, ХАЛХ ГОЛ ...

Увс аймгийн Баруунтуруун сумын Засаг даргын Тамгын газрын дарга М.ЭРДЭНЭ-ОЧИР:

“Би энэ албыг 15 дахь жилдээ хашиж байна. Шинээр батлагдсан “Орон нутгийн хамгаалалтын тухай хууль”-д аймаг, сумдын Засаг даргын Тамгын газрын дарга нарын гүйцэтгэх үүрэг, ач холбогдол эрс нэмэгдсэн. Тиймээс аймаг, орон нутагтаа Булган хамгаалах үйл ажиллагааг явуулах гол бүрэлдэхүүн хэсэг нь бид юм.

Хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд хэд хэдэн ажлыг төлөвлөдөг байна. Үүн дээр нэмж өнгөрсөн сард манай аймагт “Монгол цэргийн нэгдсэн холбоо” ТББ-ын салбар холбоо



байгуулагдсан нь бидний ажилд ихээхэн тус нэмэр болох сайхан боломж бүрдлээ гэж харж байна. Энэ ажлын хүрээнд Чөлөөлөх

дайны ялалтын ойд зориулан түүх, дурсгалт газруудаар хийх аяллыг Увсаас Буйр нуур, Булан дэрс, Халх гол зэрэг эх орныхоо тусгаар тогтнол, газар шорооныхоо төлөө халуун амь бүлээн цусаа урсгасан дайчдын нутгаар өнгөрүүлэх гэж байгаадаа баяртай байна. Эргэж нутагтаа очоод Булган хамгаалах, Зэвсэгт хүчний үйл ажиллагааг олон нийтэд сурталчилж, хүүхэд, залуустаа цэрэг-эх оронч үзэл, хүмүүжлийг олгох үйл ажиллагааг төлөвлөн хэрэгжүүлэх болно.

Манайх Хилийн цэргийн ангитай бөгөөд тэнд гавьяаныхаа амралтад гарсан олон офицер, ахлагч бий. Тэдэнтэйгээ бид хамтран ажиллана.

БҮГД ЦЭРГИЙН АЛБА ХААСАН

Увс аймгийн Өндөрхангай сумын Жаргалант багийн Засаг дарга Х.ЭРДЭНЭБАТ:

“Тус аялалд хамрагдсандаа туйлын баяртай байна. Бид Увс аймгаас 1300 гаруй километр замыг туулж нийслэл хотод ирлээ. Одоо эндээсээ мөн 1000 гаруй км явж, Дорнод аймгийн Халх гол суманд очно. Би сумаа төлөөлж яваа хүн. 2012 оноос тус суманд Багийн Засаг даргаар ажиллаж байгаа бөгөөд ажиллах хугацаандаа үргэлж төрийн цэргийн байгууллагуудтай хамтран ажиллаж, тэдний үйл ажиллагааг дэмжсээр ирсэн.

Эргэж очоод сумынхаа иргэддээ холбооны үйл ажиллагааг сурталчилна. Өмнө нь би тус холбоог төрийн байгууллага гэж андуурч байсан. Судлаад үйл ажиллагаатай нь танилцаад нарийн мэдээлэл авч, ташаа ойлголттой байснаа мэдсэн. Манай багийн гэлтгүй ер нь сум, аймгийн хэмжээнд жил бүр цэрэгт алба хаах хүсэлтэй залуусын тоо нэмэгдэж байгааг энд хэлэх нь зүйтэй болов уу. Түүнээс өмнө нь залуус цэргийн албыг төдийлэн ойшоож, сонирхдоггүй байсан. Гэтэл одоо цаг үе өөр болж, залуус ирээдүйтэй алба гэдгийг нь ухаамсарлах болжээ. Тэгээд ч төрийн албанд ажилд орох үүднээс цэргийн албаа биеэр хаах хүсэлтэй болсон. Манай багаас гэхэд жилд 10 гаруй залуус цэрэгт



мордож байна. Энэ тоо цаашид ч улам нэмэгдэнэ.

Миний хувьд 1985-1988 онд Улаанбаатар хотод Ардын Армийн 019 дүгээр ангид цэргийн алба хааж байлаа. Сүүлийн гурван жилийн цэрэг явлаа. Манайх эцэг, эхээсээ арвуулаа бөгөөд долоон хүү нь бүгд цэргийн алба хаасан юм. Тиймээс цэргийн амьдрал, албаны онцлог, сайхан талуудыг нь өөрийнхөө хэмжээнд сайн мэддэг учир орон нутгийнхаа хүмүүсийг байнга уриалдаг. Харин өдгөө төрийн бус байгууллагын салбар нь манай аймагт байгуулагдаж, бүтээлч үйл ажиллагаагаа явуулах болсон учир цэрэгт алба хаах залуусын тоо эрс нэмэгдэнэ гэдэгт илтгэлтэй байна.

ЧӨЛӨӨЛӨХ ДАЙНЫ ЯЛАЛТЫН 75 ЖИЛИЙН ОЙД

ГУРВАН ДАЙНД ОРОЛЦСОН ЦЭРГИЙН ЭМЧ БУЮУ



Монгол Улсын гавьяат эмч, гурван дайнд оролцсон ахмад дайчин Лувсангийн ШАРАВДОРЖ

Өнгөрсөн жил Батлан хамгаалах яамны дэмжлэгтэйгээр эх орон даяар зохион байгуулсан "Бессмертный полк" буюу "Мөхөшгүй мөнхийн хороо" жагсаалын үеэр нэгэн содон ахмад дайчны түүхийг өгүүлэн самбар барьж зогссон эрхэмтэй уулзсан юм. Тэр нь нэрт тархины мэс засалч, клиникийн профессор Шаравдоржийн Болд байлаа. Түүний эцэг хурандаа Л.Шаравдорж нь эх орныхоо тусгаар тогтнолын төлөө бүхий л амьдралаа зориулж, дайчин алдарт замнал туулсан хүн байсныг хүү Болдоос нь сонсож бахархах сэтгэл төрсөн ба аавынхаа дурсамжийг өвөөч гэвэл дуртайгаар зөвшөөрсөн юм.

Хувьсгалт тэмцлийн ахмад зүтгэлтэн, Монгол Улсын Хүний гавьяат эмч, хурандаа Лувсангийн Шаравдорж 1912 онд Цэцэн хан аймгийн Дарьганга хошуу, одоогоор Сүхбаатар аймгийн Халзан суманд төрсөн. Хошууны бага сургууль төгсөөд 1932 оноос Дорнод аймгийн Баянтүмэн суманд хоньны аж ахуйд малчин, гар үйлдвэрт гуталчнаар ажиллаж байгаад 1934 онд цэргийн албанд татагдсан. 1934-1938 онд Зөвлөлт Холбоот Улсын Лениград хотноо Цэргийн хүн эмнэлгийн дунд сургуулийг төгссөн ба Ардын цэргийн 6 дугаар морьт дивизийн 15 дугаар морьт хорооны эмнэлгийн албаны даргаар Халх голын байлдаанд оролцсон. Дайны дараа цэргийн дарга нарын курст суралцсанаар 1940 оны 5 дугаар сараас Дотоод явдлын яамны Эмнэлгийн албаны дарга, Цэргийн нисэхийн хорооны Эмнэлгийн албаны даргаар ажиллаж байсан. Улмаар 1940-1944 онд ЗХУ-д С.М.Кировын нэрэмжит Цэргийн хүн эмнэлгийн академид суралцсаны дотор Ленинград хотын бүслэлтэд тулалдаж байсан.

1944-1945 онд Д.Сүхбаатарын нэрэмжит Офицерын сургуулийн эмчээр ажиллаж байгаад Чөлөөлөх дайнд Өвөр байгалийн фронтын 2 дугаар бүлгийн эмнэлгийн албаны даргаар оролцсон. Чөлөөлөх дайны дараа 1945-1956 онд Цэргийн төв госпиталийн дарга, 1956-1967 онд

Улаанбаатар Төмөр замын Эмнэлэг, ариун цэврийн албаны орлогч дарга, албаны дарга, 1967-1978 онд УБТЗ-ын төв эмнэлгийн физик эмчилгээний тасгийн эмч, эрхлэгч, 1978-1982 онд "Баянбуурал" амралтын эмч зэрэг ажлуудыг хийж явсан юм.

Саяхан Аугаа их Эх орны дайны ялалтын 75 жилийн ойг тохиолдуулан Улаанбаатар төмөр замын эмнэлгийг Хувьсгалт тэмцлийн ахмад зүтгэлтэн, Монгол Улсын Хүний гавьяат эмч, хурандаа Лувсангийн Шаравдоржийн нэрэмжит болгосон нь бидэнд бахархах сэтгэлийг төрүүлж билээ.

Нэг. ДОМОГТ ХАЛХЫН ГОЛД

Японы түрэмгийлэгчид Бүгд Найрамдах Монгол Ард Улсад Халх голын районоор халдан өнгөлзөж, 1939 оны нэгдүгээр сараас тавдугаар сарыг хүртэлх хугацаанд 30 гаруй удаа хил зөрчих болов. 1939 оны гуравдугаар сард 6 дугаар дивизийн 15 дугаар морьт хорооноос Халх голын чигт хил хамгаалах хүчийг зузаатгахаар салааны дарга Очир, бага дарга Батаа, Самбуу, Балдандагва



Баянцагааны тулалдаанд Японы гол хүч байрлаж байсан Талын манханыг чөлөөлсний дараа маршал Х.Чойбалсантай уулзаж байгаа нь. Өвөр эгнээд зүүн гар талаас штабын дарга, хожим нь хорооны дарга болсон Ш.Дарамжав, хорооны эмч, орчуулагч Л.Шаравдорж, хорооны сургагч С.В.Кравченко, хамгийн баруун захад хорооны улс төрийн сургагч Халимов болон бусад дайчид

нарын бүрэлдэхүүнтэй 70 орчим шилдэг байлдагчийг явуулж Сүмбэр болон дайсан нэвтэрч болох зарим эмзэг газраар хилийн хамгаалалтад байрлуулсан нь маш чухал үүрэгтэй байлаа. Тухайлбал, салааны дарга Очир дайсны тагнуулуудыг хэд хэдэн удаа илрүүлэн устгаж байсан ба дайсны барааны газраас үзэгдэхэд морин дээрээс нударгалан буудаад хэд хэдээр нь унагаадаг хэмээн хил хамгаалж байсан цэргүүд шагшин магтаж байсан юм. Очир үнэхээр зоригтой, самбаатай дарга байсан. Түүнийг Халхын голын ялалтын 30 жилийн ойн баяраар Сүхбаатарын одонгоор нэхэн шагнасан билээ. Улмаар 1939 оны 5 дугаар сарын 11-ний өдрөөс япончууд цэргийн их хүчээр БНМАУ-ын дархан хилийг 15 километр цөмөрч Халхын голд дайн дэгдсэн юм.

Зургаадугаар дивизийн дарга Шаарийбуу хороодын дарга, штабын дарга, комиссар, тусгай анги, салбарын дарга нарыг цуглуулж, цагийн байдал, дайсны хүчний байршилг танилцуулахдаа 15 дугаар хорооноос хүч нэмэгдүүлсэн суман гаргаж Хамар давааны ар шил, Баянцагаан давж, Халх голыг



Л.Шаравдорж Халхын голын дайны дараа

тагнахад дайсны морин ба моторт ангиудаас бүрдсэн ихээхэн хүч байна гэсэн мэдээ авсан. Танк эсэргүүцэх буу хоёр, пулемётын салаа, мөн хөнгөн пулемёт, гранат бусад зэвсгээр сайн ханга, бэлтгэлээ сайн хангаж, маш сонор сэрэмжтэй давш. Дайсан Халх голыг гаталсан байвал давшилтыг зогсоож, хориглож байлд. Мэдээг морин холбоогоор ирүүлж бай гэж тушаасан юм.

Дайсны эсрэг Хязгаарын цэргийн харуул болон 6 дугаар дивизийн түрүүчийн ангийн дайчид хэд хоногийн турш сөрөн тулалдаж, дайсныг Халх гол гатлуулахгүйгээр араас гол хүчээ очтол няцаан барьж байлаа. Ар талаас Зөвлөлт-Монголын цэргийн хүч нэмэгдэн ирж 5

дугаар сарын 22, 23, 24-ны өдрийн ширүүн тулалдаанаар харийн түрэмгийлэгчдийн давшилтыг зогсоон ухрааж, Халх голын зүүн эргийн ноёлог өндөрлөгүүдийг эзлэн хориглолт хийсэн. Эхний тулаанд бут цохигдсон дайсан ар талаасаа үлэмжхэн хэмжээний хүчийг яаралтай татан, манайхаас явган цэргээр 3.5, пулемётгоор 1.3, танк эсэргүүцэх их буугаар 2 дахин давуу хүчийг татаж, хуримтлуулжээ.

Манай дайчдын байлдах чадвар, улс төрийн идэвх, ёс суртахуун хэмжээлшгүй өндөр байгаа нь энэхүү тулалдаанаар харагдаж байсан. Шаарийбуугийн командалсан 6 дугаар дивиз байлдаанд орсны 16 дахь өдрийн албан мэдээнд "...ядарсан, зүдэрсэн хүнгүй, цөм японы самуурай нарыг дахин улам хатуу цохино хэмээн ярилцаж байхын дээр ар талд байр сахих хүн олдохгүй, хүн бүхэн байлдахыг хүсэж шаардаж байна" гэж бичигджээ.

1939 оны 5 дугаар сарын 25-ны өдөр 15 дугаар хорооны дарга тэр үеийн хэлмэгдүүлэлтэд өртөж, хороо эзгүйрсэн тул хорооны комиссар С.В.Кравченко эмнэлгийн албаны дарга, хэлмэрч-орчуулагч Л.Шаравдоржийг хороо командалж явах тушаал өгсөн. Ийнхүү байлдааны дунд үе хүртэл Л.Шаравдорж дайсны эсрэг 60 гаруй тулалдаанд хороогоо командалан оролцжээ. Дайны дунд үед дивизийн даргын тушаалаар штабын дарга Шагжийн Дарамжав 15 дугаар морьт хорооны даргаар дэвшин, дайны төгсгөл хүртэл хороогоо захирч, ялалтад хүргэсэн ба гарамгай удирдагч болохоо нотолсон юм.

Л.Шаравдорж хорооныхоо эмнэлгийн албыг удирдаж, дайсны шуурган галын дундаас шархадсан дайчдаа аварч, татан гаргахын зэрэгцээ хорооны сургагч С.В.Кравченкогийн хэлмэрч байсны хувьд хороо эзгүйрсэн үед хороогоо командалж тулалдаанд орох үүргийг давхар гүйцэтгэж байжээ. Мөн Зөвлөлт-Монголын ангуудын хооронд холбоо барих, С.В.Кравченкогийн хамт шөнийн цагт дайсны хүчийг тагнах, дайсны цөмрөн орж ирэх болзошгүй газарт хөнгөн пулемёттой отолт хийх, дайчдын дунд улс төрийн ухуулга хийх зэрэг үүргүүдийг хавсран гүйцэтгэж байжээ.

Фронтын шугам дээр шуудан зөөгчийн цүнх хэвтэж, хажууд нь олон захиа салхины аясаар хийсэж байхыг олж, захидлуудыг нь цуглуулж байтал Дугарын Рэгээдмаагаас гэсэн өөрт нь хаягласан захиа байхыг задалж уншаад маш их баярлаж, өөрийн эрхгүй нүдний нь нулимс гарч, анх удаа хүүтэй болсноо мэдсэнээр дайныг түргэн дуусгаж гэртээ харих юм сан хэмээн ихэд яарч байжээ. Гэргий Рэгээдмаа нь 6 дугаар дивизийн ар талд бусад дарга, офицеруудын гэргий нарын хамт сувилагч-санитараар ажиллаж, шархадсан дайчдыг сувилах, асрах цаг

наргүй үйлсэд зүтгэж байсан нь "Эх орны төлөө" сонин (1939 (39)-0627 №12)-д "Эмэгтэйчүүд ар талын ажилд оролцож байна" гарчгийн дор... Ахмад Дандарын командалсан эмнэлгийн газар жижүүрийн сувилагч, санитарын ажлыг гүйцэтгэж буй Рэгээдмаа, Жавзмаа нар уул санитарын ажлыг гүйцэтгэж буй үедээ мэргэжилтний зааврын ёсоор өвчтэй байлдагчдын хоол ундыг тухай бүрд нь тасралтгүй нийлүүлж, гагцдандгүй байлгасан хийгээд мөн ариун цэврийн талаар шил, аяга, цонх, сандал, ширээ гэх зүйлүүдийг туйлын сайнаар арчлан цэвэрлэж байсан. ... Иймд манай бусад эмэгтэйчүүдээс эмнэлгийн ажилд энэчлэн гавшгайгаар тусалж байхыг уриалъя" хэмээн бичигджээ.

1939 оны 5 дугаар сарын 27-28-ны шилжих шөнө хилийн Цагаан овоо, Номун хаан, Бүрд овоогоор Хайлааст голын чигт 15 дугаар хороо руу дайсны их хүч чиглэн давшлаа. Хорооны хучийг хоёр хувааж комиссар С.В.Кранченко Л.Шаравдоржийн хамт үлдэж, нөгөө хэсгийг штабын дарга Дарамжав авч хоёр суман цэргийн хамтаар Ц.Лувсаншарав, Баадай нарын суманг, Б.Батцэнгэл даргатай наводчик Нянзаадарийн танк эсэргүүцэх 45 мм-ийн их буутай хамт үүр цайхаас өрсөж байрлалаа эзлэн дайсанд гэнэтийн цохилт өгчээ. Эхний машиныг их буугаар сөнөөв. Дайсан их хүчээр явгалан давшиж, байлдааны ажиллагаа хүндрэх төлөвтэй ирсэн хоёр машин дүүрэн цэргийг олзлон авч чадсан юм. Энэ тулалдаанд Мазимын Экей сайн байлдаж, баатарлагаар амь үрэгдсэн бөгөөд 1979 онд Халхын голын байлдааны ялалтын 40 жилийн ойн баяраар БНМАУ-ын баатар цолыг нэхэн олгосон юм.

1939 оны 9 дүгээр сард 15 дугаар хороо Тамсагбулагт хүрэлцэн ирж ялалтаа тэмдэглэж хуралджээ. Хорооны дарга Дарамжав, сургагч С.В.Кравченко, улс төрийн сургагч Халимов нар бүх дайчдад ялалтын баяр хүргэж, "Бусдыгаа манлайлан байлдсан Баадай, Очир, улс төрийн удирдагч Лувсаншарав, эмнэлгийн албаны дарга Шаравдорж, бага эмч Дондов, пулемёт сумангийн дарга Б.Буд, ухуулагч Дэмчиг, Самбуу, Л.Шагжаа, Батаа, Шараа, Нянзаадарь, Жадамбаа, Дашдондог, Чойжил зэрэг олон дайчдыг нэрлэж болох байна" хэмээн тэмдэглэжээ. Энэ үед "Зөвлөлт-Монголын ган бат найрамдал, түүний үр шим яамдаж баршгүй арвин билээ. Бид хамтын хүчээр нийтийн дайсныг даран сөнөөж хүндтэй гавьяа байгууллаа. Энэ бол т бидний зүй ёсны бахархал мөн" хэмээжээ. Дивизийн комиссар Пэлжээ тус хуралд оролцож, 15 дугаар хороо маш сайн байлдаж, эх орныхоо өмнө хүлээсэн үүргээ нэр төртэй биелүүлсэнд баяр хүргэсэн юм

Өдөржин тулалдсанаас сум, галт хэрэглэл бага болж, байдал хүндэрч байсан боловч ар талаас сумаар хангагдан иртэл тогтоон барьж байсан юм. Зөвлөлт-Монголын их буучид ил ба далд хараагаар дайсны дээрээс галт бөмбөг буулгаж, түүний доогуур Б.Будын удирдсан пулемёт сумангийн шөргөн галын дэмжлэгтэйгээр манайхан сөрөг давшилтад орсон. Элст манхны араар ороож ирээд хориглолтод орж амжсан дайсан манай давшилтын хүчийг тогтоон барьж дийлэхгүй бут цохиулсан юм. Энэ өдрийн тулалдаанд сайн байлдсан учир 1939 оны 5 дугаар сарын 29-ний өдрийн "Эх орны төлөө" сонинд "... намын гишүүн Л.Шаравдорж манлайлав" гэж бичсэн байлаа.

Маргааш нь хорооны эмч Л.Шаравдорж, их бууны офицер, партизан Цогт хоёул хэдэн цэргийн хамт амь үрэгдсэн дайчдын цогцыг цуглуулан тэмээн тэрэгтэй явж байтал 6 дугаар дивизийн дарга Шаарийбуу давсгаараа буудуулж, цус их алдан нас барсан байсантай тааралдан, түүний шарилыг берзинтэд ороож, дивизийн штабт хүргэж иржээ. Бүх цэргийн жанжин Х.Чойбалсангийн 76 тоот тушаалаар 6 дугаар дивизийн дарга асан баатарлаг удирдагч Шаарийбуугийн шарилыг Тамсагбулагийн хойд талын Түмэн-Өлзийт овооны нарлаг энгэрт хүндэтгэлтэйгээр оршуулсан юм. Дайны бүх хугацаанд 15 дугаар хороо дивизийнхээ /авангард/ цохих тэргүүнд явж, дайсантай тулгаран байлдаж байсан юм. Штабын даргаас хорооны дарга болж дэвшсэн Дарамжав "Эх орон бидний аминаас илүү үнэтэй. Нэгийг алдвал солио, хоёрыг алдвал хожоо" хэмээн дайчдад зоригжуулан, "Хороо байлдаанд!", "Миний хойноос!" гэж командлан тулалдаан болгонд манлайлан ордог байсан. Энэ мэтээр Халх голын дайн 8 дугаар сарын сүүлч, 9 дүгээр сарын эхэн хүртэл үргэлжилсэн аж.

Наймдугаар сарын 17-ны өдөр Япончууд дахин их хэмжээний хүчийг хуримтлуулан өргөн фронтоор давшиж эхэлсэн боловч гурван өдрийн турш манай цэргийн ширүүн дайралтад бут цохиулсан юм. Наймдугаар сарын 19-ний орой 6 дугаар дивиз дайсны гол хүчийг устгахад 15 дугаар хороо шийдвэрлэх үүрэг гүйцэтгэсэн билээ. Дайсны гол хүчний хойд, зүүн хойд жигүүрээс бүслэн шахаж, Эрс уулнаас Баянцагааны хойд хөндий хүртэл 80 шахам километр өргөн фронт дээр хориглолт байгуулан, бүслэн авч 8 дугаар сарын 20-ны өглөө эрт Гөлөгт манханыг чөлөөлж, дайсныг устгасан. Энэ үед дайсны талаас хүч нэмэгдүүлж ирсэн хоёр машин дүүрэн цэргийг олзлон авч чадсан юм. Энэ тулалдаанд Мазимын Экей сайн байлдаж, баатарлагаар амь үрэгдсэн бөгөөд 1979 онд Халхын голын байлдааны ялалтын 40 жилийн ойн баяраар БНМАУ-ын баатар цолыг нэхэн олгосон юм.

1939 оны 9 дүгээр сард 15 дугаар хороо Тамсагбулагт хүрэлцэн ирж ялалтаа тэмдэглэж хуралджээ. Хорооны дарга Дарамжав, сургагч С.В.Кравченко, улс төрийн сургагч Халимов нар бүх дайчдад ялалтын баяр хүргэж, "Бусдыгаа манлайлан байлдсан Баадай, Очир, улс төрийн удирдагч Лувсаншарав, эмнэлгийн албаны дарга Шаравдорж, бага эмч Дондов, пулемёт сумангийн дарга Б.Буд, ухуулагч Дэмчиг, Самбуу, Л.Шагжаа, Батаа, Шараа, Нянзаадарь, Жадамбаа, Дашдондог, Чойжил зэрэг олон дайчдыг нэрлэж болох байна" хэмээн тэмдэглэжээ.

Энэ үед "Зөвлөлт-Монголын ган бат найрамдал, түүний үр шим яамдаж баршгүй арвин билээ. Бид хамтын хүчээр нийтийн дайсныг даран сөнөөж хүндтэй гавьяа байгууллаа. Энэ бол т бидний зүй ёсны бахархал мөн" хэмээжээ. Дивизийн комиссар Пэлжээ тус хуралд оролцож, 15 дугаар хороо маш сайн байлдаж, эх орныхоо өмнө хүлээсэн үүргээ нэр төртэй биелүүлсэнд баяр хүргэсэн юм

ЧӨЛӨӨЛӨХ ДАЙНЫ ЯЛАЛТЫН 75 ЖИЛИЙН ОЙД

ЧӨЛӨӨЛӨХ ДАЙНД ЦЭРГИЙН ЭМНЭЛГИЙН ГҮЙЦЭТГЭСЭН ҮҮРЭГ



Ленинград хот, Цэргийн эмнэлгийн академийн сонсогчид, 1941-1944 он. Урд эгнээнд зүүн гар талаас Ш.Даш, Л.Шаравдорж, Ц.Дашцэрэн, арын эгнээнд Ш.Цэрэнжав, Г.Довдон

гэж түүний дурсамжид бичигджээ.

Хоёр. ЛЕНИНГРАД ХОТЫН ХАМГААЛАЛТАД ОРОЛЦСОН МОНГОЛ ЭМЧ НАР

Л.Шаравдоржийг Халх голын дайны дараа Дотоод явдлын яамны эмнэлгийн албаны дарга, Цэргийн нисэхийн хорооны эмнэлгийн албаны даргаар ажиллаж байхад нь маршал Х.Чойбалсан дуудаж ЗХУ-ын Ленинград хотноо Цэргийн хүн эмнэлгийн академид суралцуулах болсныг мэдэгдэж, 1940 оны 9 дүгээр сард хэсэг нөхдийн хамт ЗХУ-ыг зорин очжээ.

Ленинградын бүслэлтэд байсан тухайгаа Л.Шаравдорж дурсан бичихдээ: "1941 оны зуны амралтаараа нутаг руугаа явцгаахаар эхэж, шалгалтуудаа өгч байтал Зургаадугаар сарын 22-ны өдөр Гитлерийн Герман итгэлийг эвдэж, ЗХУ-д гэнэт довтолсон учир академи зун амрахгүй болж хичээлээ шахсан ба өдөрт 10-12 цаг хичээллэх болсон. Ленинград стратегийн чухал ач холбогдолтой хот байсан учир Гитлерийн илгээсэн фельд маршал Фон Леебийн командалсан 500 мянган хүнтэй арми 9 дүгээр сарын 8-ны өдөр 2.5 сая хүнтэй хотыг хуурай замаар бүслэсэн юм. 1941 оны 9 дүгээр сард өдөр бүр бороо орж, хааяа сэв хийвэл хар үүл багтаж ядан нүүгэлтэй нар үзэх нь өдрийн од шиг ховор байлаа. Үүлний цоорхой, борооны чөлөөгөөр германы онгоц элээ шиг дээгүүр эргэхэд зенитийн мэргэн буучид үзэгдсэн дор нь устгах юм уу үлдэн хөөдөг сөн. Бид өглөөнөөс орой хүртэл төрөлх хотоо хамгаалахын төлөө нойр, хоолгүй ажиллаж байгаа хотын оршин суугчдын хамт мөрөндөө буу үүрч, гартаа хүрз барин танкны саад ухаж, хаалт, хамгаалалт хийж оройн цагаар хичээлээ хийнэ. Их хотын дээгүүр утаа унир хөшиглөн бараантан дарь хүхрийн үнэр хямар цоргиж, хотын гудамж эл хуль хааяа бүрэн зэвсэглэсэн цэргийн жагсаал шир шир хийн өнгөрөх нь сэтгэлд нэгийг бодогдуулна. Бид хичээлд суухдаа үзэг, дэвтэртэйгээ, ажилд гарахдаа хүртэйгээ, байлдал буутайгаа бэлэн байдаг байлаа. Хонх дуугарч сургуулийн клубт цуглаан болж орлогч захирал индэрт гарч "Нөхөд өө, Гитлерийн Германы фашистын манай хотод 10-аад километр ойртжээ. Октябрийн хувьсгалын өлгий хотыг харийн дайсны гарт өгөхгүй байхыг Зөвлөлт засаг, коммунист нам Улаан

армид болон Ленинградчуудад даалгасан байна" гээд өөрийн сургуулийн өмнө тулгарч байгаа үүрэг, зорилтыг нарийвчлан ярьж билээ. Монгол оюутнууд бид академийн захирал Маслов дээр орсон бөгөөд фронтд явж Зөвлөлтийн ард түмэнтэй хамт байлдах хүсэлтээ гаргасан юм. Захирал бидэнд "Та нар бидний хамт Ленинградыг хамгаалах үүрэг биелүүлэх болно" гэж билээ. Шагдарын Даш, Гомбын Цэрэнжав, Гонсын Довдон, Цэвээнжавын Дашцэрэн, Бадамын Дамбийням, Мөрхүүгийн Жанчивдорж бид Ленинградчуудын нэгэн адил 6 сар 20 хоног бүслэлтэд орж эдүгээгийн Баатар хотыг хамгаалсан юм даа. Энэ үед Ленинград хот бүслэгдэн галт хэрэгсэл, зэвсэг, техник, хүнс тэжээл хомсдон байдал маш хүнд байсан ба олон хүн амь насаа алдаж байсан. Хотыг тойруулан танкны саад байгуулах, далан шуудуу ухах, шөнийн цагт харуул манаанд гарах, үе үе дайсан цөмрөх үед дайсны өөдөөс хориглон байлдах ба сөрөг давшилт хийх, аврах группэд оролцон нурсан байшин, хонгилоос осолд нэрвэгдсэн хүмүүсийг гаргах, шатаагч бөмбөгнөөс хотыг цэвэрлэх, шархадсан хүмүүст эмнэлгийн анхны тусламж үзүүлж, эмнэлэгт хүргэх зэргээр унтах нойр, амрах чөлөөгүй хүнд хэцүү амь өрсөн цаг байсан ч дайсны эсрэг тэмцэхийн хажуугаар үргэлжлүүлэн суралцаж байсан нь сургуулийн захирал, хошууч генерал Маслов, анатомийн багш профессор, дэслэгч генерал Тонков, мэс заслын багш, хошууч генерал Березно болон Долговесников, Аничков зэрэг өндөр боловсролтой олон шилдэг эрдэмтэн багш нарын минь уйгагүй хөдөлмөр, ач тусыг нь дурдах нь зүйтэй. Тухайн үед 1941, 1942 оны өвөл -40 хэм хүрсэн тэсгэм хүйтэн байж билээ. Далайн эргийн чийглэг уур амьсгалтай газрын 40 хэм манай хуурай уур амьсгалтай газрын 50-60 хэмтэй тэнцэнэ. Хот бүхэлдээ цахилгаан, дулаангүй хөлдөж, хүйтнийг тэсвэрлэхэд бэрх байсны зэрэгцээ хүнсний нөөц дуусаж, хотод өлсгөлөн нүүрлэн, олон мянган хүн өлсөж, хөлдөж үхэж байлаа. Бид бүгд Оросын ард түмэнтэй нэгэн адил өлсгөлөн, хүйтнийг тэсвэрлэн, Ленинградчуудтай мөр зэрэгцэн хотыг хамгаалж тулалдсан.

Тэр үед манай ард түмний хэн ч байсан Ленинградыг хамгаалахад амь бие хайрлахгүй

оролцох нь мэдээж байсан юм. Бидний хувьд Оросын Октябрийн хувьсгалын өлгий хотыг хамгаалах үйл хэрэгт тийнхүү оролцсон нь бахархалтай санагддаг юм даа. Монгол оюутнууд бид энэхүү бүх саад бэрхшээлийг амжилттай даван туулж билээ.

1942 оны 2 дугаар сарын сүүлчээр Ленинградын бүх сургууль, цэргийн академиудыг бүслэлтээс татан гаргах гарц Ладог нуурын мөсөн замаар арагш нь нүүлгэн шилжүүлсэн. Хэдийгээр нуурын мөс цөмрөхийн зэрэгцээ германчууд зогсоо зайгүй бөмбөгдөж байсан ч бидний аз түшин бүслэлтээс эсэн мэнд гарч Москвад хүрээд, цааш Узбекийн Самарканд хотод очиж хурдавчилсан байдлаар сургалтаа үргэлжлүүлэн Б.Дамбийням, М.Жанчивдорж хоёр 1943 онд төгсөж, Г.Дондов, Г.Цэрэнжав, Ш.Даш, Ц.Дашцэрэн бидний таван нөхөд 1944 оны хавар сургуулиа төгсөөд ачааны машинаар эх орныхоо торгон хил дээр эсэн мэнд ирснээр бие биеэ тэврэн уйлагдаж, "Югтай ч хэдүүлээ эх орныхоо барааг ингэж хардаг аа" хэмээн хэмжээлгүй их баярлацгааж билээ. Биднийг дээд командлалын шийдвэрээр "Ленинград хотыг хамгаалсны төлөө" медалиар шагнаж, Аугаа их Эх орны дайны ялалтын 45 жилийн ойн баяраар "Дайнд оролцсон Зөвлөлтийн ахмад дайчин" гэсэн цол, тэмдгээр шагнасан юм.

Ленинград хот бол миний амьдралтай салшгүй холбоотой. Хожим нь хүний гавьяат эмч хэмээх тэрхүү нэр хүндтэй алдрыг хүртэх эхлэлийг энэ л хотоос, Зөвлөлтийн ард түмнээс гардан авсан. Тэгээд ч эх орны их дайны бэрх цагийн үйл явдлууд сэтгэл зүрхэнд хэзээ ч балрахгүйгээр хоногшин үлджээ. Хамт сурч байсан нөхөд минь цөм хороо, дивизийн эмч, хээрийн хөдөлгөөнт госпиталиудын удирдлагаас гараагаа эхэлж, бүгд 1945 онд Японы түрэмгийлэгчдийг даран сөнөөх Чөлөөлөх дайнд оролцсон "Хувьсгалт тэмцлийн ахмад зүтгэлтнүүд" бөгөөд М.Дамбийням

удаа зөрчсөн нь тэмдэглэгдсэн байдаг.

Зөвлөлт Холбоот Улс 1945 оны 8 дугаар сарын 8-ны өдөр Японы эсрэг дайн зарласан. Тус улс Алс дорнодод байлдааны ажиллагаа явуулахын тулд гурван фронтоор давшилтад орсон. Түүний нэг болох Өвөр байгалийн фронтын бүрэлдэхүүнд Зөвлөлт-Монголын морьт механикжуулсан бүлэг багтаж 8 дугаар сарын 10-ны өдөр эх орныхоо торгон хилийг давсан юм. Энэхүү бүлгийг ЗХУ-ын баатар, гвардын хурандаа И.А.Плиев командалсан ба түүний бүрэлдэхүүнд маршал Х.Чойбалсангийн командалсан Монголын Ардын цэргийн анги, нэгтгэлүүд Зүүн хойд Хятадын нутагт хоёр чиглэлээр давсан юм. Түүний нэг дэх нь Чуулалт хаалганы чиглэл. Тэрхүү чиглэлийн анги, нэгтгэлүүд Жанчхүүгийн давааны ард хэд хоног ширүүн тулалдаан хийсэн юм. Хоёр дахь нь Долнуур, Жэхэ, Гуэйкоу чиглэлд хоёр долоо хоног 1000 километр замд давсан. Энэ бүлгийн бүрэлдэхүүнд Зөвлөлтийн мотобуудлагын 27 дугаар бригад, 59 дүгээр морьт дивиз, зенитийн их бууны хороод, сөнөөгч онгоцны ангиудаас гадна генерал Ч.Доржпалам, хурандаа М.Цэдэн-Иш, Г.Дорж, дэд хурандаа М.Одсүрэнгийн командалсан 5, 6, 7, 8 дугаар морьт дивиз, хурандаа Д.Нянтайсүрэнгийн командалсан танкийн гуравдугаар тусгай хороо, дэд хурандаа Төрхүүгийн командалсан их бууны хороо, нисэх хүчний холимог дивиз багтаж байсан. Тус бүлгийн эмнэлгийн албаны даргаар Лувсангийн Шаравдорж томилогдон бригад, дивиз, хорооны хүн эмнэлгийн алба, хээрийн госпиталийг дайны талбарт зангидан удирдаж, тэдний эмнэлгийн шаардлагатай бүх үйлдлээр хангаж, үйл ажиллагааг уялдуулан зохион байгуулан олон зуун дайчдын амь насыг аварч чадсан юм. Хээрийн хөдөлгөөнт эмнэлгийг орон тоо, эм багаж хэрэгслээр хангах, хээрийн болон ар талын госпиталиудыг зохион байгуулах, Зөвлөлтийн армийн госпиталиудтай хамтран ажиллаж

эмнэлгийн анхны тусламжийг үзүүлэх зэргээр гарамгай сайн ажилласнаар олон хүний амь насыг аварч, үүргээ онцгой сайн гүйцэтгэсэн юм. Бас бага эмч Зундуй, Жанлав, Чимэддорж, эмийн санч Сосор, сувиллагч Норовдаваа, Отгон, Дашцэрмаа нар үүргээ чадамгай биелүүлсний дурдах учиртай. Дайны өдрүүдэд манай эмнэлгийн албаныхан нийт 2239 шархтанд эмнэлгийн тусламжийг үзүүлсэн бахдам тоо, баримт байдаг юм. Энэхүү хариуцлагатай үүргийг нэр төртэй гүйцэтгэхэд 8 дугаар дивизийн их эмч Г.Цэрэнжав, хошууч Мажаев, их эмч Довдон, ахмад Мальцев, 5 дугаар дивизийн их эмч, хурандаа Антоненко, хошууч Сахренко, 6 дугаар дивизийн их эмч, ахмад Бондарчук, их бууны хорооны их эмч Лобовкин, Өмнөд группийн эмч хангамжийн дарга Сандуйжав, бага эмч Мижд, Нацаг, их эмч Г.Даш, их эмч М.Жанчивдорж, Чойжилсүрэн, сувиллагч Буниа нарын гавьяа, зүтгэл маш их байлаа.

Энэхүү Чөлөөлөх дайнд ар талын госпиталийн даргаар дэвшиж ажилласан Г.Цэрэнжавын удирдсан Баянтүмэнгийн госпиталь, Б.Дамбийнямын удирдсан Сайншандын госпиталиуд фронтоос ирсэн өвчтөн ба шархтнуудад эмнэлгийн нарийн мэргэжлийн тусламжийг шуурхай үзүүлж, олон мянган хүний амь нас, эрүүл мэндийг аварсныг тэмдэглүүштэй.

Манай армийн хээрийн госпиталиуд Жанбэй, Жэхэ, Долнуур хот Бандид гэгээний хийд, Губэйкоу хот зэрэгт төвлөрөн байрлаж Зөвлөлт-Монголын эмч, эмнэлгийн ажилтан, ажилчид хамтарч нэг баг болцгоож ажилласан. Бүх цэргийн жанжин, маршал Х.Чойбалсан, Армийн Улс төрийн газрын дарга, дэслэгч генерал Ю.Цэдэнбал, Бүх цэргийн жанжны орлогч, дэслэгч генерал Ж.Лагасүрэн нар манай хээрийн госпиталийн ажлуудтай танилцаж, энэхүү дайнд цэргийн эмнэлгийн албаны гүйцэтгэсэн үүргийг өндөр үнэлж фронтын эмнэлгийн албаны дарга Л.Шаравдоржийг "Алтан



Зүүн гар талаас БНМАУ-ын баатар Д.Данзанваанчиг, Л.Дандар, Н.Мандах, С.Дампил, Ж.Нэхийт, гавьяат эмч Л.Шаравдорж

маань Монголын анхны нэртэй мэс засалч, "Рентген"-ий хэмээн алдаршсан Ш.Даш маань хүний гавьяат эмч, "Хамар хоолой"-н гэж алдаршсан Г.Цэрэнжав мөн хүний гавьяат эмч, Ц.Дашцэрэн Анагаах ухааны дээд сургуулийн анатомийн багш, Г.Довдон БХЯ-ны эмнэлгийн хэлтсийн дарга, М.Жанчивдорж халдвар судлалын нэртэй эмч, би өөрөө хүний гавьяат эмч болсон доо хэмээн дурсамжаа үлдээжээ.

Гурав. ЧӨЛӨӨЛӨХ ДАЙНД ЦЭРГИЙН ЭМНЭЛГИЙН ГҮЙЦЭТГЭСЭН ҮҮРЭГ
Л.Шаравдорж ЗХУ-ын Цэргийн хүн эмнэлгийн академи төгсөж ирээд 1944 оны 7 дугаар сараас 1945 оны 7 дугаар сарыг хүртэлх хугацаанд Офицерын сургуульд Эмнэлгийн албаны дарга, эмчээр ажилласан. И.В.Сталин 1945 оны хоёрдугаар сард Ялтын уулзалт дээр Германыг бууж өгсний дараа 2-3 сар болоод Японтой дайтахаар холбоотнуудтайгаа тохирсон билээ. БНМАУ-ын түүхэнд Японы түрэмгийлэгчид 1939-1945 онд манай улсын хилийг 500 гаруй


байсны дээр дээд боловсролтой төрөл бүрийн мэргэжилтнээр хангагдаж байжээ.

Дайн эхэлсэн анхны өдрүүдээс дайсан манай цэргийн давшилтын замын дагуух худаг усыг "стрихнин" гэдэг хороор хордуулан байсныг армийн эмнэлгийн хайгуулынхан илрүүлж, хоргүйжүүлэн ариутгах, шинээр худаг ус гаргах зэргээр Зөвлөлт-Монголын дайчдын зогсолтгүй давших нөхцөлийг хангаж байсан юм. Энэ дайнд Ц.Дашцэрэнгийн удирдсан хөдөлгөөнт тавдугаар госпиталь, их эмч Шагдарын Даш, сургагч хошууч Петрухин нарын удирдсан эмнэлгийн албаныхан үүргээ маш сайн биелүүлж 270 гаруй шархтанд эмнэлгийн тусламжийг үзүүлж, ар талын госпиталиуд руу татан гаргалт хийж байлаа. Бага эмч Ламчогдон, ротын ариун цэврийн зааварлагч Дамдинжав, пулемёт ротын ариун цэврийн зааварлагч Агаарамхан, их бууны батарейны ариун цэврийн зааварлагч Цэрэн нар дайсны мөндөр мэт суман доогуур амь бие хайргүй тэмцэн явж олон шархтныг тулалдааны талбараас гаргах,

гадас" одонгоор шагнаж, Өвөр Монгол болон Хятадын дарлагдсан ард иргэдийн зан заншил, ёс суртахуун, шашин шүтлэгийг хүндэтгэж, тэдэнд хүнлэг ёсоор нигүүлсэнгүй хандаж, боллоцоотой бүх тусалцааг үзүүлэхийг дахин дахин анхааруулжээ. Түүний дагуу нутгийн дөрвөн мянга орчим ардуудад эмнэлгийн тусламжийг үнэ төлбөргүй үзүүлэн тэдний талархлыг хүлээж байжээ.

Дайны дараа буюу 1945 оны сүүлчээр энэхүү нийтлэлийн гол эзэн Л.Шаравдорж Цэргийн төв госпиталийн даргаар томилогдон 10 гаруй жил тус эмнэлгийг удирдахдаа энх цагийн бүтээн байгуулалтын нөхцөлд цэргийн госпиталийг шинэчлэн зохион байгуулж, цаашдын хөгжлийн чиг хандлага бодлогыг тодорхойлолцсон хүн гэдгийг ахмад үеийнхэн дурсан ярьдаг билээ. Эх орон, тусгаар тогтнол, эрх чөлөөнийхөө тэмцэлд халуун амиа хайрлаагүй цэргийн эмч нарын гавьяаг бид мартаж учиргүй.

Хурандаа Б.ОТГОНБОЯР, бэлтгэл хошууч С.БОЛД



Дугаарын зочин

Энэ дугаарын зочноор "Positive Mongolia" контентгыг үүсгэн байгуулагч Э.ДӨЛГӨӨНТЭЙ ярилцлаа. Тэрээр энэхүү контентоороо хүмүүст зөв үлгэр дуурайлал өгч, хосуудын амьдрал ийм байдаг шүү гэдгийг харуулахыг зорьдог ажээ.

Та яагаад Швед улсад ажиллахаар очсон юм бэ?

-Манай ээж Швед улсад 11 жил амьдарсан ба том эгч минь арван настайгаасаа очоод өдийг хүртэл ажиллаж, амьдарч байна. Мөн манай үеэлүүд ч байдаг болохоор Швед рүү явсан. Ойр дотнын хүмүүс их байдаг болохоор ч тэр юм уу, Швед рүү л явчих юм бол бүх зүйл сайхан болох шиг санагддаг байлаа.

Яг хэзээ явъя гэсэн шийдвэрт хүрсэн бэ?

-Нөхөртэйгөө танилцаад хамтын амьдралаа эхлүүлэх гэтэл орон сууц, унах унаа гээд бүх зүйл хэрэгтэй болсон учраас бид хоёр ярилцаад Швед рүү явах шийдвэрийг гаргасан. Мөн ханийн маань ээж өвчтэй байсан учраас тэнд эмчлүүлэе гэсэн шийдвэрт хүрсэн.

Хэлний бэрхшээлтэй хэр их тулгарч байсан бэ?

-Мэдээж, тулгаралгүй яах вэ. Би амьдралдаа швед хэлийг сонсож байгаагүй. Тийм болохоор сурахад анхандаа маш хэцүү санагдаж байсан.

Хэл сурсан дурсамжаасаа сонирхуулбал...

-Анх очоод "Улаан загалмайн нийгэмлэг"-ийн хэлний сургалтад суусан. Сайн дурын ажил байсан учраас орон орны хүмүүс ирж суралцдаг юм билээ. Багш нар нь хүнд ойлгуулахын төлөө, сургахын төлөө чин сэтгэлээсээ хичээлээ заадаг. Тэндээ ойр зуурын хэрэгцээний үгсийг уншиж бас ярьж сураад хэлний бэлтгэлд шалгалт өгч тэнцсэн. Ингээд ахисан шатны буюу хоёрдугаар түвшний сургалтад хамрагдаж швед хэлний дөртэй болсон доо.

Шведэд байхдаа тус улсын туршлагаас эх орондоо хэрэгжүүлж болох ямар санааг авсан бэ?

-Өөр газар, өөр орчинд хүн анх очихоороо бүх зүйл нь сонин содон санагддаг юм байна лээ.

ЭХ ОРОНЧ ХҮНИЙ ЧҮЛДЭЛ ЖИЖИТХЭН ЗЧҮЛЭЭС Ч ХАРАГДАДАТ



Харин яваандаа дасаад ирэхээр нөгөө их гайхаж байсан зүйлс нь өдөр тутмын байдаг л зүйлс шиг санагддаг. Миний бодлоор манай улсад хамгийн их хэрэгтэй зүйл нь нийтийн тээврийн асуудал. Шведэд энэ асуудлыг маш нарийн зохицуулалтаар шийдэж чадсан ба трамбай, метро, автобус зэрэг нийтийн тээврийн төрөл олонтой. Мөн хүмүүс нь үнэхээр соёлтой. Жишээ нь, автобус ирэх цагаасаа хоцрох юм бол жолооч нь "Хоцорсонд уучлаарай" гэж хүндэтгэлтэйгээр хэлдэг. Хүмүүс

нь хүртэл шаардлага тавиад сурчихсан. Тиймээс манай оронд нэвтрүүлэх чухал туршлага нь нийтийн тээврийн зохицуулалтын асуудал бас хариуцлага юм.

Зам нь түгжрэлтэй юу?

-Бараг л үгүй. Хотын төв рүү ороход зам ашигласны төлбөр гэж хураамж авдаг бас зогсоол олддоггүй, олдсон нь өндөр төлбөртэй байдаг. Хувийн хэвшлийн машин гэдэг ойлголт бага. Тийм болохоор түгжрэл бараг л байхгүй.

Таны "Vlog"-ийг үзэхэд

хосуудын амьдралын мөн чанар, үнэ цэн, бие биеэ хайрлан халамжлах гээд олон сайхан зан чанарыг хүмүүст уриалсан байдаг. Хамгийн анхны дугаараа хаанаас санаа авч хийсэн бэ?

-Би зурагт үзэх дуртай. Зурагтаар гадаадын сонирхолтой олон нэвтрүүлгүүд гардаг. Бүгд "Vlog" маягаар хийгддэг. Эндээс л санаагаа авсан гэхэд болно. Тухайн үед Монголд "Mongolian family" гэж "Vlog" хийгдэж байсан. Тэр үеэс хойш гадаадын "Vlog"-чдыг харж, судалж байгаад энэхүү контентгыг эхлүүлсэн.

Хамгийн анхны дугаараа цацахад хүмүүс хэрхэн хүлээж авсан бэ?

-Яг үнэндээ хамгийн анхны "Vlog"-ийг маань хүмүүс ерөөсөө үзээгүй. Яагаад үзэхгүй байгаа талаар бодож үзсэн л дээ. Ерөнхийдөө урьдчилан бэлтгэж, тавилттай байдлаар хийгээд хэрэггүй юм байна гэсэн дүгнэлтэд хүрсэн. Харин бэлдсэн зүйлгүйгээр өөрийнхөөрөө хийгээд үзье гэж бодсон. Тэгж хийсний дараагаар "Vlog"-ийг маань үзэх хүмүүс олширч, санал хүсэлт, магтаал, шүүмжлэл ч нэлээд ирэх болсон.

Эсрэг, сөрөг сэтгэгдлүүдэд ямар хариу үйлдэл үзүүлдэг байв?

-Ганц сөрөг хандлагатай комент ирэхэд л тэр өдөржингөө бодогдоод хямрах үе гардаг байсан. Тэр үед нөхөр маань тусалж дэмждэг байсан. Магадгүй тэр мань байгаагүй бол шантраад замын дундаас буцчих байсан даа гэж боддог. Сүүлдээ нэг их хүндээр хүлээж авахаа больсон. Гэхдээ байнга сэтгэгдлээ шалгадаг хэвээрээ. Яагаад гэвэл хүмүүсийн санал хүсэлтийг харж, санаа авч дараа дараагийнхаа уран бүтээл, ажил хөдөлмөрөө үргэлжлүүлдэг.

Та "Хосын жор" хэмээх ном гаргасан. Номоо бичиж байхдаа тулгарч байсан асуудлуудын талаар...

-Яг өөрийнхөө амьдралаас тулгуурлан бичсэн. Номоо

эцсийн байдлаар бичиж дуусгаад хэвлүүлэхийн өмнө гурван хүнээс зөвшөөрөл авсан. Хамгийн эхний хүн нь миний ээж. Дараа нь нөхрөөсөө, тэр минь надад "Татгалзах зүйл байхгүй. Би зөвшөөрсөн юм чинь бусад хүмүүс юу гэж бодох нь нэг их хамаагүй" гэж хэлсэн. Сүүлд нь хүүгээсээ зөвшөөрөл авсан. Хүү маань ээжээ, энэ таны л туулсан амьдрал юм чинь та хэвлүүлэх үгүйгээ өөрөө мэд гэж хэлсэн. Товчхондоо ийм.

Таны хувьд эх оронч хүн гэж хэнийг хэлэх вэ?

-Анх эх оронч хүн гэхээр дайн, байлдаанд оролцож тэмцэж байсан, газар нутгаа өөриймшүүлсэн хүмүүсийн талаар боддог байлаа. Харин одоо эх оронч хүний үйлдэл жижигхэн зүйлээс ч харагддаг болсон. Миний хийж байгаа ганцхан зүйл л эх орныхоо төлөө гэсэн сонголт мөн үү, үгүй юу гэж бодох болсон. Жишээ нь, үндэсний үйлдвэрлэлээ дэмжих, Монголдоо үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг авч хэрэглэх нь эх орныхоо төлөө хийж байгаа миний хөрөнгө оруулалт юм байна гэж бодож байна.


Зэвсэгт хүчний талаар юу гэж боддог вэ?

-Нөхөр бид хоёрыг Шведэд байхад нэг террорист үйл ажиллагаа болсон юм. Хотын төвөөр нэг хүн тэсрэх бөмбөг тавьсан гэж мэдэгдээд эмх замбараагүй байдал үүсгэсэн. Энэхүү үймээн самууны үеэр биднийг Зэвсэгт хүчнийхэн л хамгаалж байсан. Маргааш нь Шведийн олон иргэн тэрхүү үймээн гарсан талбайд цугларан "Бид та нараас айхгүй байна" хэмээх уриа, лоозон барин нэгдэж, жагссан. Ингэхдээ Зэвсэгт хүчний бүрэлдэхүүнд цэцэг өгөн талархсанаа илэрхийлж тэвэрч байсан нь миний сэтгэлийг маш их хөдөлгөсөн шүү. Биднийг ямагт амар тайван байх нөхцөлийг хангадаг бүрэлдэхүүн нь Зэвсэгт хүчнийхэн юм. Тиймээс бид тэднээр ямагт бахархах учиртай.

Оюутан Г.НАНДИНТУЯА

УРГАМЛЫН ТООСЖИЛТООС ХЭРХЭН СЭРГИЙЛЭХ ВЭ?

Ургамлын тоос агаарт цацагдахад гурван үе шаттай байдаг. Эхнийх нь 5 дугаар сард ихэсдэг хус, бургас зэрэг модны тоосжилтын оргил үе. Дараа нь 6 дугаар сарын 20-ноос 7 дугаар сарын эхэн үе хүртэл үргэлжилдэг үет ургамлын тоосжилтын үе. Гуравдугаарт нь илүү хүчтэй тоосжилтын үе буюу шарилж, лууль (олон наст ургамал, нэгэн төрлийн шарилж), хамхуул, агь зэрэг ургамлын үе юм. Ургамлын тоос нь нарны гэрэлд хүмхын тоос шиг үзэгддэг. Нүдэнд үл үзэгдэх ургамлын тоос амьсгалын замаар орж харшлын шинж тэмдгийг илрүүлдэг. Мөн нүдний салстад бууж нүдний харшил үүсгэх гол эх үүсвэр болдог. Хамрын болон нүдний харшил зэрэг явагддаг нь ийм учиртай. Шалтгаан дангаар байгаад өвчин үүсгэдэггүй. Заавал нөхцөл бүрдэж байж нөхцөл үүснэ. Харшил үүсэхэд нөлөөлөх гол нөхцөл нь агаарын бохирдол, тухайн хүний удамшлын байдал, дархлааны дарангуйлах чадвар



зэргээс хамаарна. Агаарын бохирдлыг бууруулж, зэрлэг ургамал тоосоо гөвөх цагаас урьтаж цэвэрлэгээ хийн харшлаас сэргийлэх боломжтой.

Ургамлын тоосжилтоос өөрийгөө хамгаалахын тулд ямар ургамлаас харшилтайгаа эхлээд мэдэх хэрэгтэй. Мөн тэр ургамалтай ямар хүнсний бүтээгдэхүүн холбогддогийг мэдэх хэрэгтэй. Жишээлбэл, шарилжийн тоосжилтоос харшилдаг хүн багваахай, балжингарам цэцгийн найрлагатай бүтээгдэхүүн хэрэглэхэд тохиромжгүй. Мөн айраг уух, түүхий лууван, улаан лооль зэргийг идэхэд тохиромжгүй. Ургамлын тоос өглөө нар гарахаас эхлэн үд дунд хүртэл агаарт тархдаг. Тодруулбал шарилж, луулийн тоосжилт өглөөний 04.00-09.00 цаг хүртэл, оройн 17.00-22.00 цаг хүртэл үргэлжилдэг байна.

ЭМГЭНЭЛ

БЭЛТГЭЛ ХУРАНДАА ЦЭРЭНДОРЖИЙН ДОРЖХҮҮ (1954-2020 он)

Зөндөө удаан амьдарсан мэт санагдавч зөрөг замын цэцгэн дээр тогтсон шүүдрийн чийг мэт замхарч одох зөн совинт орчлонгийн хүмүүн заяа гэгч зөөлөн борооны дараа тэнгэрт татах солонго лугаа ажаам.

Сайр шандын усыг шавхарна чинээ бодоогүй байтал сансрын од хүртэл сарниж оддог хорвоод сайн хүн нь муугаасаа олон гэлцэх олны үг үнэн. Тэдний нэг бол тэр хийгээд тэмээн жингийн цуваа тэнгэр зүглэж хөвөрсөн тэгнээ ачаат амьдралаас харваж одсон од буюу. Өдрийн од жаргаж, үдшийн одод түгэв.

Үдшийн одтой тэнгэрийн гэгээнд үүрд оршсон газар дэлхийд эгэл бус боловч эгэл бусаа мэдээгүй эрхэм хүмүүний үлдээсэн мөр үл арилах... Тэр бол тэрний мөр, тэнгэр, газар хоёроо тэвэртээ багтааж явсан цэрэг хүний тангараг бөлгөө.

Бидний дотнын нөхөр бэлтгэл хурандаа Цэрэндоржийн Доржхүү 2020 оны 8 дугаар сарын 8-ны өдөр өвчний учир тэнгэрт од болон харваж, газарт зул болон асав.

Тэрээр 1954 онд Улаанбаатар хотод төрж, 1972 онд УБТЗ-ын 20 дугаар дунд сургууль, 1976 онд Жанжин Д.Сүхбаатарын нэрэмжит Цэргийн ерөнхий дээд сургууль, 1987 онд хуучин ЗХУ-ын Ю.Гагарин нэрэмжит Агаарын цэргийн академи, 1995 онд ОХУ-ын Стандартчилал, хэмжил зүйн дээд курс, 2004 онд БНХАУ-ын Үндэсний Батлан хамгаалахын академийн Батлан хамгаалахын судалгаа, шинжилгээний институтэд тус тус суралцаж төгссөн ба цэргийн шинжлэх ухааны магистр, холбооны инженер, команд штаб-оператив тактик, хэмжил зүйч мэргэжлийг эзэмшжээ.

Ц.Доржхүү 1976-1979 онд АА-ийн 123 дугаар ангид салааны захирагч, 1979-1980 онд АА-ийн 189 дүгээр ангид тасгийн дарга, 1980-1982 онд АА-ийн 180 дугаар нэгтгэлд холбооны офицер, 1982-1983 онд АА-ийн 193 дугаар тусгай салбарын захирагч, 1987-1989 онд Зэвсэгт хүчний 137 дугаар ангийн холбооны албаны дарга, нисэх тусгай хорооны захирагчийн 1 дүгээр орлогч, штабын дарга, 1989-1993 онд Зэвсэгт хүчний 315 дугаар ангийн анхны захирагч, 2002 онд ЗХЖШ-ын техникийн хяналтын албаны дарга, Зэвсэгт хүчний ерөнхий хэмжил зүйч, улсын байцаагч, 2002-2005 онд Зэвсэгт хүчний Цэргийн хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангах албаны орлогч дарга, 2005-2009 онд Зэвсэгт хүчний Хяналт шалгалт, үнэлгээний газрын дарга, Монгол Улсын Засгийн

газрын тогтоолоор Стандартчилал, хэмжил зүйн үндэсний зөвлөлийн гишүүнээр 1996-2009 онд томилогдон ажиллаж байгаад 2009 онд цэргийн тэтгэвэрт гарсан.

Түүний хөдөлмөр бүтээл, улс орныг батлан хамгаалах үйл хэрэгт оруулсан хувь нэмрийг нь төр, засгаас өндрөөр үнэлж, Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одон, Цэргийн гавьяаны улаан тугийн одон, Цэргийн гавьяаны одон, Цэргийн хүндэт медаль, Ардын хувьсгалын 60, 70 жилийн ойн медаль, "Энхийн төлөө" медаль, Ардын Армийн 50 жил, Зэвсэгт хүчний 60 жилийн ойн медаль, ОХУ-ын "Дайчин нөхөрлөл", Их Монгол Улс байгуулагдсаны 800 жилийн ойн медаль, маршал Г.К.Жуковын медаль, 2001 онд Стандартчилал, хэмжил зүйн тэргүүний ажилтан, 2003 онд Төрийн хяналтын тэргүүний ажилтан, 2006 онд Зэвсэгт хүчний Жанжин штабын Тэргүүний ажилтан, 2008 онд Бүртгэл-статистикийн тэргүүний ажилтан цол, тэмдгээр шагнажээ.

Хурандаа Ц.Доржхүү цэргийн тэтгэвэрт гарсан боловч цэргийн албанаасаа бие, сэтгэлээ салгалгүй нэгэн үзүүрт сэтгэлээр зүтгэж, Зэвсэгт хүчний Хэмжил зүйн алба, Зэвсэгт хүчний Нэгдсэн лабораторийн үйл ажиллагааг хөгжүүлэн бэхжүүлэх болоод шинэ залуу үеэ халамжлан хүмүүжүүлж, сургаж бэлтгэх үйлсэд үнэлж баршгүй хувь нэмрээ өргөсөн хөдөлмөрч нэгэн байлаа.

Түүний гэгээн дүр төрх, хийж бүтээсэн үйлс, хийж бүтээхийг зорьсон хичээнгүй их хүсэл тэмүүлэл нь бидний зүрх сэтгэлд үүрд оршино.

Хэрийн дүрэмт хувцсаа хээтэй торгоор солиогүй, хээгүй бор амьдралаа хэний ч зарлигаар орхиогүй хөх монголын хөх цэрэгт хөх дэлхий мэхиймүй...

Соёмбот далбаанд тахигдаж, солонгот дэлхийд дуурьссан сод монголын цэрэг хөвгүүдийн нэг, эрхэм журмын энэрэлт сайн нөхөр танаа зул өргөж ёсолье!

Амьдрах гэж бус алба хаах гэж амьдарсан аргил боргил боловч ашид мөнх дуурьсах алдар суу дүүрэн цэрэг заяа оршиг...

БАТЛАН ХАМГААЛАХ ЯАМ, ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ ЖАНЖИН ШТАБЫН УДИРДЛАГА, ХАМТ ОЛОН, БХЯ БОЛОН ЗХЖШ-ЫН АХМАДЫН ХОРОО, ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ НИЙТ БИЕ БҮРЭЛДЭХҮҮН

Улаанбаатар хот,
Баянзүрх дүүрэг, Офицеруудын ордон
Индекс 10018

И-мэйл хаяг:
Mil_newssoyombo@yahoo.com
Утас: 70001029

СОЁМБО СОНИН
"Соёмбо" сонин 96 дахь жилдээ хэвлэгдэж байна.
Үндэслэгч нь: Н.ЖАДАМБА,
Д.НАЦАГДОРЖ

Эрхлэгч
Хурандаа
Батжаргалын
ОТГОНБАЯР

Эхийг "Соёмбо" сонин
релакад бэлтгэж,
"Соёмбо принтинг" хэвлэх
үйлдвэрт хэвлүүлэв.

*Зар, рекламгыг хямд нийтэлнэ.
*Зар, рекламгыг үнэн зөв, эсэхийг нийтлүүлсэн байгууллага, хувь хүн хариуцна.
*Зохиогчийн үзэл бодол сониний нийтлэлийн бодлогод нийцэхгүй байж болно.
*Тус сонин мэдээллийг нэр заан ашиглаж болно.